MMINFO.
19 дэх жилдээ
# МОНГОЛЫН МЭДЭЭ
Хүн ам 3,159.408... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.08.21. Даваа. №137 (4751) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +19
Шөнө +9

ОНЦЛОХ ХУУДАС

“60 ТЭРБУМ”-ЫН ХЭРГИЙГ ӨӨРСДӨӨ НОТОЛЧИХОЖ БАЙГАА ЮМ БИШ ҮҮ

V нүүрт

ЦАГ ҮЕ

Н.ЦЭДЭНДАМБА: БИ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦЫН 50 ЖИЛИЙН ТҮҮХИЙГ БИЧИЛЦСЭН ХҮН

VII нүүрт

Дугаарын 60 мөр

## Хандивд гаршсан цэцэрлэгийн бүртгэл

Б.ДАВАА

Энэ жил цэцэрлэгт шинээр элсэх хоёр настнуудын цахим бүртгэл өнгөрсөн сарын 25-наас эхэлсэн. Харин 3-5 хүртэлх насны хүүхдүүд өнөөдрөөс эхлэн азаа үзнэ. Өмнө нь улсын цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн тухайд анги дэвшихдээ ямар нэг асуудалгүйгээр бүртгүүлэх боломжтой бол хувийн цэцэрлэг болон оршин суугаа хаягаасаа шилжсэн болон огт цэцэрлэгт явж үзээгүй хүүхдийн эцэг, эхчүүд аз, эзээ үзэх билээ.

Энэ хичээлийн жилд өмнөх оны мөн үеийнхээс 9321-ээр их буюу 252753 хүүхэд цэцэрлэгт хамрагдана гэсэн тооцоо бий. Мөн 20 цэцэрлэг шинээр ашиглалтад орж, харьяаллын хүүхдүүдээ бүртгэхээр болжээ.

Цэцэрлэгүүд шинээр ашиглалтад орж, тэр хэрээр сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдүүдийн тоо нэмэгдэх нь. Гэхдээ хайхрахгүй орхиж боломгүй нэг асуудал байна.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# МАН-ынханд ӨВЛИЙГ БОДОХ СӨХӨӨ АЛГА, АМЬ АМИА БОДОЦГООО

Х.НОРЖМАА

“Мэнгэ нь голлож” гэдэг үгийг сонсч явсан ч тэгтлээ ач холбогдол өгч байсангүй. Харин ирж буй өвлийн тухай бодох бүрийд “Энэ өвлийг яаж шуухан давна даа. Олигтой зун болсонгүй. Үүл буудаж, бороо оруулах авч тэр нь хөрсөнд шингэх завдалгүй хавийн юмыг хуйлруулж одно. Хэдэн мал нь ногоо хөөвч араа шүдэнд нь ороогдох өвсгүй болохоор хамраараа шороо үмхлэх нь өрөвдмөөр. Дээр нь хаа сайгүй түймэр гарч, байгаа жаахан ойг минь тожгор болгочих шахлаа. Ядаж байхад төр, засгийнх нь байж байгааг “ гэх түгшүүр төрөх юм. Үнэндээ ч эрх барьж байгаа МАН дотроо дээр, доороо орж бужигнаад хэрэг алга. Байгаа байдал нь нэг л биш. Эрх баригчдыг улс орны байдал, намрын ургац хураалт, өвөлжилтөөс илүүтэй хариуцлагаас яаж мултрах тухай асуудал л зовоож байгаа нь сүүлийн хэдэн өдрийн үйл явдал бэлхэнээ харууллаа. Бие биеэ тагнасан чагнах нь хэрээс хэтэрч , эдүгээ намаа үгүй хийх дээрээ тулаад улсад айсуй өвөл хамаагүй байж ч мэднэ. Дээлээ нөмөрчилгүйгээр уснаас хуурай гарах талаар бодсоор нойргүй хоножк байгаа юм чинь. Нөхцөл байдал энэ чигээрээ удаан үргэлжлэх аваас цөөн хэдэн улстөрчийн бус Монгол Улсын мэнгэ голлож таарна. Дэлхий дэлгэнэсэн сайхан цаг байсан ахул өдийд хадланчид хадландаа гарч, ногоочид ургацаа хураан шинэхэн ногоотой шөлний сайхан үнэр айл бүхнээс үнэртэж, тариаланчид ангилан хадах тухай яриа өрнүүлэн, малчид өвөлжөө бууцаа эргэж тойрон засч янзлах гээд намрын нөр их ажил орон даяар давалгаалж байдагсан.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ



## Ерөнхийлөгч залуучуудтай ӨГЛӨӨНИЙ ГҮЙЛТ хийв

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга спортыг бүх талаараа дэмжинэ гэдгээ байнга илэрхийлдэг. Тэр ч утгаараа өөрөө залууст үлгэр дуурайлал болохоор энэ сарын 19-ний бямба гарагт Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд залуучуудтай өглөөний гүйлт, дасгал хийв. Гүйлтэд 30 гаруй залуус оролцсон бөгөөд Ерөнхийлөгч дасгал хэрхэн хийх талаар заавар зөвлөгөө өгсөн юм. Цахим орчинд Ерөнхийлөгчийг өөрөө үлгэрлэн, залуусыг амьдралын зөв амьдрах арга ухаанд уриалан дуудсан, эрүүл аж төрөхийн үндэс нь дасгал хөдөлгөөн гэдгийг сурталчилсан хэмээн иргэд сайшааж байлаа.




| ХААН банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2408.00 | 2422.00 | ФУНТ | 3077.00 | 3170.00 |
| ЕВРО | 2610.00 | 2677.00 | РУБЛЬ | 40.40 | 42.40 |
| ИЕН | 21.36 | 21.67 | ЮАНЬ | 347.70 | 351.10 |

| Худалдаа хөгжлийн банк | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2438.00 | 2452.00 | ФУНТ | 3090.00 | 3210.00 |
| ЕВРО | 2815.00 | 2922.00 | РУБЛЬ | 39.05 | 44.02 |
| ИЕН | 21.91 | 22.88 | ЮАНЬ | 363.00 | 367.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ




# ӨВЛИЙГ ӨНТЭЙ ДАВАХ АРГА ЗАМЫГ ХЭЛЭЛЦЛЭЭ

Э.ТУУЛ

*Өвөлжилтийн бэлтгэл хангах зөвлөгөөн өнгөрсөн баасан гарагт Төрийн ордонд болж, аймаг, нийслэлийн Засаг дарга нар нутаг орныхоо өвлийн бэлтгэл, цаг үеийн байдлаа дэлгэрэнгүй танилцууллаа. Зөвлөгөөний үдээс хойшхи хуралдаанд Засгийн газрын тэргүүн Ж.Эрдэнэбат гишүүдийнхээ хамт оролцож, Засаг дарга нар өвөлжилт төдийгүй аймаг, орон нутгийнхаа цаг үеийн тулгамдсан асуудлыг тайлбарлаж, салбарын сайд нараас хариулт авсан юм.*

## 400 мянган тн өвс, тэжээл авах хөрөнгийг шийднэ

Хөдөө аж ахуйн салбарын 2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол өнгөрөгч зургадугаар сарын 28-нд гарч, энэ дагуу нарийвчилсан төлөвлөгөө хийж, отроор өвөлжих, хаваржих өрх, малын тоог тохирч гэрээ байгуулах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг ажлыг хугацаа алдалгүй хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарт даалгасан юм. Засаг дарга нарын ярьж буйгаар өвөлжилтийн бэлтгэл аймаг бүрт харилцан адилгүй байна. Тухайлбал, мал отроор намаржих, өвөлжих газруудтай харилцан зөвшилцөж, отор хийх гэрээ хэлцэл хийхэд тусламж үзүүлэх, хадлан бэлтгэх боломжтой аймгуудад хадлан бэлтгэх зөвшөөрөл авахад дэмжлэг үзүүлэх, мал, мах бэлтгэх борлуулахад анхаарч, дотоодын махны үйлдвэрүүдтэй аймгуудаас мал, мах нийлүүлэх гэрээ хийх нөхцөл бүрдүүлэх зэрэг санал олон аймгаас гарлаа. Мөн "ОХУ-аас өвс, тэжээл авах боломж байна. Төсвийн тодотголд суулгаж, 400 мянган тн өвс, тэжээл авах хөрөнгийг шийднэ" гэдгийг Ерөнхий сайд Засаг дарга нарын асуултад хариулахдаа хэлсэн юм. Түүнчлэн энэ зуны саруудад нийт нутгаар гандуу байснаас үр тариа, улаан буудайн ургацын хэмжээ буурсан. Төмс, хүнсний ногоо, тэжээлийн таримлын ургац төлөвлөснөөс 20 орчим хувиар багасахаар мэдээлэл байна. Хадлангийн ургац оройтсон, ургац тааруу байна. Тиймээс техник, хүн хүчний боломжтой аймгууд Дорнод, Сүхбаатар зэрэг аймгийн нутгаас хадлан бэлтгэх саналууд гарч байгаа ажээ. "Ийм саналаа аймаг, сумууд манай яаманд ирүүлээрэй. Бид зуучилж, зохицуулж өгнө" гэж ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн энэ үеэр хэллээ.

## Малын өвчлөлгүй нутагт тусгай бүс тогтоож, эрүүл бүсээс мал, мах экспортлох ажлыг хийнэ

Засгийн газар мал, мах бэлтгэж, экспортлоход анхаарч, хэд хэдэн улс оронд гаргаж эхлээд байна. Мах бэлтгэх үйлдвэрийн үйл ажиллагааг сайжруулах, мах бэлтгэдэг хүмүүст Засгийн газар дэмжлэг үзүүлнэ. Мөн малын өвчлөлгүй нутагт тусгай бүс тогтоож, малчдаас худалдаж авсан малаа тэнд тусгаарлаж, энэ эрүүл бүсээс мал, мах экспортлох ажлыг хийхээр төлөвлөж байгаа. Малаа эрүүл байлгах, өвчин гарахаас урьдчилан сэргийлэх нь малчдын үүрэг. Орон нутгийн удирдлагууд малчдын ийм хариуцлагыг нэмэгдүүлэхэд зөвлөгөө зөвлөмж хүргүүлж, тусалж дэмжиж ажиллах ёстой гэдгийг Ерөнхий сайд тэмдэглэлээ. ОХУ-ын хүмүүнлэгийн тусламжаар ирүүлэх шүлхийн вакцины эхний ээлжийн тарилгыг хүлээн авч өвчин гарсан аймгуудад вакцинжуулах ажил хийгдэж байгаа юм байна.

## П.Сэргэлэн: Гурилын үнэ өсөхгүй

*/ХХААХҮ-ийн сайд/*

Зөвлөгөөний үеэр Увс зэрэг аймаг гурил импортоор авах хүсэлт тавьж байсан юм. ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн энэ асуултад "Энэ жил 170 мянган тн улаанбуудай гаднаас авна. Харин гурил импортоор авахыг зөвшөөрөхгүй. Дотоодын үйлдвэрлэгчдээ дэмжинэ, гурилын үнэ өсөхгүй гэж" хариуллаа. Гантай жилийн үрийн будаа маш чанартай байдаг гэж тариаланчид зөвлөж, хэлдэг. Иймд ирэх жилийн үрийн будааг дотоодоосоо 100 хувь хангана. Энэ зөвлөмжийг тариаланчдадаа дамжуулаарай гэж Ерөнхий сайд хэлээд ер нь Монголдоо үйлдвэрлэдэг бараа, бүтээгдэхүүнийг Монголоосоо л худалдаж ав, дотоодын үйлдвэрлэл, аж ахуйн нэгжээ дэмж. Монголд үйлдвэрлэдэг бараа бүтээгдэхүүнийг гадаадаас авч буй тохиолдолд хариуцлага тооцох болно гэдгийг Засаг дарга нарт тэрээр анхааруулав.

## Хүний эрүүл мэндийг хамгаалахын төлөө зүтгэж буй хүмүүс унаагүй байж болохгүй

Засаг дарга нар сумын эмнэлэгт түргэний машин хэрэгтэй, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ муу, ирэх онд улсын төсвөөр баригдах сургууль, цэцэрлэгийн тоонд тухайн аймаг, сумынх багтсан эсэхийг салбарын сайд нараас тодруулж байлаа. 2017 оны улсын төсөвт аймаг, сумдын эмнэлгийг түргэн тусламжийн унаатай болгох хөрөнгө суусан. Гэсэн ч зарим аймгийн Засаг дарга нар сумын эмнэлэгт унаа байхгүй, олгоогүй гэдгийг хэллээ. Энэ үеэр ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат "Төсвийн хөрөнгөөр энэ жил түргэний 163 тэргийг аймаг, сумын эмнэлэгт өгсөн. Одоо улсын хэмжээнд 32 сумаас машины захиалга ирээд байгаа" гэхэд "Хүний эрүүл мэндийг хамгаалахаар ажиллаж буй хүмүүс унаа, машингүй нүцгэн гүйж байж таарахгүй. Энэ 32 машины хөрөнгийг энэ оны төсвийн тодотголд суулгаж ондоо багтаан олго" хэмээн Ерөнхий сайд ЭМ-ийн сайдад үүрэг болгов. Түүнчлэн сум, аймгийн Засаг даргын Тамгын газрын унааны асуудал ч зөвлөгөөний үеэр хөндөгдөж байсан. Тухайлбал, Баянхонгор аймагт л гэхэд 10 сумын Тамгын газар унаагүй гэдгийг Засаг дарга нь тодотгож байсан бөгөөд төлөвлөгөө гаргаж, аймаг, сумыг унаажуулна гэдгийг Засгийн газрын тэргүүн амлалаа. Зөвлөгөөний үеэр аймгийн Засаг дарга нар цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийг мөн ярьж байлаа. Энэ асуултад Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр "Гадаадын зээл, тусламжаар аймгуудын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажил хийгдэж байгаа. 2018 онд орон нутгийн цэвэрлэх байгууламжийн 50 хувийг шинэчлэхээр ажиллаж байна. Энэ шинэчлэл цаашид ч үргэлжилнэ" гэв.

> ..."Төсвийн хөрөнгөөр энэ жил түргэний 163 тэргийг аймаг, сумын эмнэлэгт өгсөн. Одоо улсын хэмжээнд 32 сумаас машины захиалга ирээд байгаа" гэхэд "Хүний эрүүл мэндийг хамгаалахаар ажиллаж буй хүмүүс унаа, машингүй нүцгэн гүйж байж таарахгүй. Энэ 32 машины хөрөнгийг энэ оны төсвийн тодотголд суулгаж ондоо багтаан олго" хэмээн Ерөнхий сайд ЭМ-ийн сайдад үүрэг болгов...

## Өвөлжилт хүндэрвэл хамтын хүчээр даван туулна

Аймаг, орон нутгийн удирдлагууд, хил залгаа аймаг, сумууд бие биедээ тусалж, хамтарч ажиллаарай. Цаг хүндэрвэл, энэ цагийг бид хамтын хүчээр давна. Засгийн газар аймаг, орон нутаг малчдаа дэмжиж ажиллана гэдгийг Ерөнхий сайд зөвлөгөөний үеэр хэд хэдэн удаа дурьдлаа. Өр төлбөртэй аймгийн, ялангуяа өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой хөрөнгийн асуудлыг Сангийн яам даруйхан шийдэж өгөхийг үүрэг болгоод амралтын энэ өдөр Сангийн яам болон бусад шаардлагатай яам, агентлагууд ажиллаж, Засаг дарга нартай уулзан, орон нутгийн ажлаа зохицуулах, асуудлыг нь шийдэж өгөхөд анхаарч ажиллахыг хүслээ. Өр нэхэхээс айж зугтаад байхааргүй ажиллах боломжийг Засаг дарга нарт олгох учиртай. Харин нэмж дахин өр төлбөрийн асуудал гаргахгүй ажиллах учиртайг Ерөнхий сайд зөвлөөд энэ тохиолдолд хариуцлага ярина гэдгийг онцоллоо. Засгийн газрын гишүүдэд аймгуудыг хуваарилж хариуцуулсан. Засгийн газрын гишүүд, сайд нар хариуцсан аймгийнхаа цаг үеийн байдлыг сайтар судалж, шаардагдах арга хэмжээг шуурхай зохион байгуулах үүрэгтэй. Цаг хүндэрсэн, байгалийн болзошгүй гамшиг тохиолдсон үед ч тухайн аймгийнхаа удирдлагатай хамтран ажиллана. Иймд өвөлжилтийн бэлтгэл хангах болон бусад асуудлаар хариуцсан сайдтайгаа ярилцаж, Засгийн газрын хуралдаанд ажлаа танилцуулан шийдүүлэх боломж бүрдсэн гэдгийг Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Засаг дарга нарт хэллээ.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Алтны компаниудад хийсэн шалгалтын дүнг Засгийн газарт мэдээллээ

БОАЖ-ын сайд Д.Оюунхорол болон БОАЖЯ-ны газар, хэлтсийн дарга нар гол мөрнийг бохирдуулах, байгаль орчинд хохирол учруулах зэрэг зөрчил гарган ашигт малтмалын олборлолт явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг Засгийн газрын хуралдаанд танилцууллаа.

Өнгөрсөн долдугаар сар болон энэ сарын эхэнд БОАЖЯ-ны газар, хэлтсийн дарга нараар ахлуулсан ажлын хэсгийнхэн Архангай аймгийн Цэнхэр, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө, Дархан-Уул аймгийн Шарын гол, Төв аймгийн Заамар, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт алт олборлож байгаа компаниудын үйл ажиллагаанд шалгалт хийсэн юм. Шалгалтын дүнг танилцуулсантай холбоотойгоор Засгийн газрын "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын хэрэгжилтийг бүрэн хангуулах, эвдэрсэн газрын тооллого хийх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт Ерөнхий сайд үүрэг болголоо. Мөн дээрх аймгуудын нутаг дэвсгэрт хуулиар хориглосон ойн сан болон усан сан бүхий газарт хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийг албадан нүүлгэх арга хэмжээ авахыг эдгээр аймгийн Засаг дарга нарт үүрэг болгож, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг дэвсгэрт хууль бусаар алт олборлон байгаль орчинд ихээхэн хэмжээний хохирол учруулсан "Рич Мөнх" ХХК-тай холбоотой зөрчлийг хуулийн хүрээнд шийдвэрлэх, байгаль орчинд учирсан хохирлыг бүрэн тооцож, нөхөн төлүүлэхээр боллоо.

## БНСВУ-ын Элчин сайд ИЖБ-ээ өргөн барилаа



Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад БНСВУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Доан Тхи Хыөнг Итгэмжлэх жуух бичиг барив. Итгэмжлэх жуух бичиг барьсны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Элчин сайд Доан Тхи Хыөнгийг хүлээн авч уулзлаа. Элчин сайд Доан Тхи Хыөнг Монгол Улсын Төрийн тэргүүнээр сонгогдсонд нь баяр хүргэсэн БНСВУ-ын Ерөнхийлөгч Чан Дай Куангийн мэндчилгээг уламжилж, Монгол Улсад улсаа төлөөлөн ажиллах болсондоо баяртай байгаагаа илэрхийлэв. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНСВУ-ын Ерөнхийлөгч Чан Дай Куанд хариу талархаж буйгаа илэрхийлээд Монгол Улсад Элчин сайдаар томилогдон ирсэнд нь хатагтай Доан Тхи Хыөнгд баяр хүргэж, цаашид ажил хэргийн уулзалтууд хийж, хамтран ажиллана хэмээлээ. Мөн Монгол Улсын төр, засгийн байгууллагуудын зүгээс Элчин сайдын ажилд шаардлагатай бүх талын дэмжлэг үзүүлнэ гэсэн юм. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдаар ажиллаж байхдаа БНСВУ-д айлчилж, харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр тодорхой ажлууд хийж байснаа дурьдав. Уулзалтын үеэр Элчин сайд Доан Тхи Хыөнг Вьетнам Улсад тохиолдсон дайны хүнд жилүүдэд Монголын төр, засаг, ард иргэдийн зүгээс тус улсад тал бүрийн тусламж, дэмжлэг үзүүлж байсныг одоо хүртэл вьетнамчууд санан дурсдаг гэлээ. Уулзалтад УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд, албаны бусад хүмүүс байлцлаа.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

## ҮЗЭЛ БОДОЛ

# МАН-ынханд ӨВЛИЙГ БОДОХ СӨХӨӨ АЛГА, АМЬ АМИА БОДОЦГОО

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Харин одоо хураах ногоо ховор, өвс хадах талбай байхгүй, тарианы болц муу гээд болж бүтэх зүйл маруухан байна даа. Тэгэхээр өвөл ямаршуухан болох нь тов тодорхой. Ус цаг уурын хүрээлэн зуны дунд сараас олон жилийн дунджаас хүйтэн өвөл болох талаар анхааруулаад эхэлсэн. ХХААХҮ-ийн яамны мэдээллээс харахад ирэх өвөл 49 сая толгой мал өвөлжих аж. Уг нь 60–аад сая толгой мал тоолуулсан л даа. Мэдээж, хүйтэн өвлийн сургаар 20 шахам сая нь идшинд бэлтгэгдэж таараа. Тэгээд ч өнөөдрийн байдлаар гаднаа хураах байтуйгай хадах өвсгүй шахам суугаа малчид юугаараа тэр их малыг тэжээх болж байна вэ. Эдүгээ сураг тавихад, Сэлэнгэ аймагт боодол өвс ширхэг нь 25-30 мянга хүрч магадгүй гэж дуулдаж байхад говийн малчдад ямар үнээр очих нь ойлгомжтой. Түүнийг нь дийлж авах малчин хэд билээ. Нөгөөтэйгүүр, газрын гарц муу учраас малын тэжээлийн хомсдол ч нүүрлэнэ. Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгжүүд малын тэжээл тарихаа бараг л больсон. Даршийг олон жил хадгалж болдоггүйн дээр эдийн засгийн хувьд ашиг муутай гэж үздэг юм билээ. Хур борoo элбэгтэй, сайхан зун хэдэн жил үргэлжилсэн тул манайхан тэр л янзаараа байх юм шиг санасаар ирсэний гайг ирэх өвөл амсах нь бололтой. Хоёр хөрш ч экспортлох хэмжээний малын тэжээл бэлтгээгүй гэж дуулдсан. Байгаль цаг агаарын хувьд ч адилхан зун болж өнгөрсөн.

Хөдөө, орон нутгийн удирдлагууд хэдэн малаа аль аймгийн нутагт оторлуулах талаар өдөр шөнөгүй ярилцавч, хүний малыг бүү хэл өөрийн малыг яая гэж байгаа улс өөр аймгийн малыг хүлээж авахгүй гэцгээн хэл үг болцгоож байгаа дуулдах юм. Сүүлийн жилүүдэд жил дараалан гарч буй малын гоц халдварт өвчнүүд дандаа отрын болон дамжин өнгөрсөн гадны малаас халдварласан талаар Дундговь, Өмнөговь аймгийн Засаг дарга нар өнгөрсөн өвөл ярьж байсан. Хоттой хонио хэдэн зуугаар нь хиаруулж орхисон малчид үлдсэн хэдээ вакцинд хамруулж, эрүүлжүүлж авсан эсэх нь эдүгээ эргэлзээтэй. Ер нь манай малчид малаа эрүүлжүүлэх асуудлыг хангай дэлхий, бурханд даатгачихаад сууж байдаг гэмтэй. Малын эмч нар ч малаа эрүүлжүүлэх асуудалд малчид тун хойрго ханддаг талаар байнга ярьж байдаг. Тиймээс малаа эрүүлжүүлж чадаагүй малчид отор хийх аваас бусдын малыг сүйд хийж л таарна. Энэ талаар орон нутаг, малын эмч нар өнгөрсөн хавар хэдэнтээ чуулсан. Үр дүн нь ирэх өвөл харагдах биз. Отор нүүдэл одоо ч үргэлжилсээр байгаа. Газрын гарц, ногооны сөл хайсан малчид хэдэн аймгийн нутаг дамжин, эдүгээ бараг л Туулын хөндийд тулж ирээд байгаа байх. Төв аймгийн Алтанбулаг сум гадны тууварчид, оторчдод эзлэгдсэн, бэлчээрийн даац хэтэрсэн талаар Засаг дарга нь мэдээлэл хийж байсан. Дархан-Уул, Сэлэнгэ аймаг ч ялгаагүй. Отрын нутаг гэгддэг Хэрлэнбаян-Улаанд малын гоц халдварт өвчний голомттой тул өнгөрсөн өвөл отрын мал хүлээж аваагүй. Тэгэхээр өвс гайгүй ургасан байж мэдэх ч өвчний голомт бүрэн арилаагүй тохиолдолд дахиад л хэдэн зуун мянган малын толгойг “залгиж” орхино. Малчид ч тийшээ малаа оторлохыг хүсэхгүй болов уу. Тиймээс малчид минь эртхэн амь амиа бодож, өвс тэжээлээ бэлдэж, отор нүүдэл хийх газраа зөв сонгохгүй бол хаврын урт өдрүүдийг давж гарахад тун хүнд байж мэднэ.

Хатуу хэлэхэд, тэр жилийн бичин жилийн зуданд Баянхонгор аймаг хамаг малаа барж орхисон шиг эмгэнэлт явдал давтагдахгүй гэх газар үгүй. Аягүй бол ирэх оны мал тооллогоор Монгол Улс 49 сая толгой малынхаа талыг зуданд тавиад туучихсан байх вий. Урьдын адил арга барагдах цагт төр, засаг атга өвс тэврээд ирдэг юм гээд гэдсээ илээд хэвтэж явж болохгүй шүү, малчид аа. Энэ бол зөвхөн мал аж ахуйн салбарынханд өгч буй сануулга. Ногоочид хийгээд тариаланчид ч асуудал бий нь ойлгомжтой. Өнгөрсөн хавар шатахууны болоод үрийн зээл авсан тариаланчид ирэх аравдугаар сараас авсан ургацаараа банкны зээлээ төлөх учиртай. Хур борoo бага, газрын чийг муу байгаагийн улмаас га талбайгаас хураах ургацын хэмжээ муу байгаа талаар Газар тариалан эрхлэгчдийн холбоо хэдийнэ мэдэгдээд эхэлчихсэн. Ийм нөхцөлд Монгол Улс улаанбуудай гаднаас импортолж л таарна. Цаг сайхан, ургац сайн байх үед гурилын үйлдвэрүүд дотоодын буудайгаа чанарын шаардлага хангадаггүй гээд гаднаас улаанбуудай импортлож байсан юм чинь. Үүнийг дагаад гурилын үнэ, түүнээс улбаатай талх, нарийн боовны үнэ нэмэгдэх л байх. Эцсийн дүндээ энэ бүхэн улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж, хямарч ядаж байгаа эдийн засагт нэрмээс болох нь дамжиггүй. Манай улсын эдийн засгийн чадавхи ямар байгаа билээ. Хоёр жил дараалан байдгаа бартал сонгуульдчихсан байдаг. Одоо бидэнд ганцхан зам байна. Тэр нь авлигад өгсөн 60 тэрбум төгрөг болон оффшор бүст байршуулсан мөнгийг эргүүлэн татаж улсынхаа эдийн засагт эргэлдүүлэх явдал. Монгол Улсын Ерөнхийлөгч ч энэ талаар байр сууриа илэрхийлсэн шүү дээ.



## Дугаарын 60 мөр

# Хандивд гаршсан цэцэрлэгийн бүртгэл

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Жил бүр л яригддаг өнөөх хандив. Саяхан нэг танилтайгаа утсаар ярилаа. Тэднийх гурван настай хүүхэдтэй юм. Өмнө нь сугалаанд аз таарaлгүй хувийн цэцэрлэгт нэг жил хүүхдээ хүмүүжүүлсэн учир энэ жил харьяаллынхаа цэцэрлэгт оруулах санаатай “таньдаг хүн байна уу” гэж сураглаж байх жишээтэй. Учрыг нь лавлавал, тухайн харьяаллынх нь цэцэрлэгт хүүхдээ явуулдаг эмэгтэй “500 мянган төгрөг атгуулчихвал асуудалгүй” гэж зөвлөсөн юм байх.

Уг нь хууль дүрмээрээ бол хэн ч цэцэрлэгийн аль нэг албан хаагчид хандив нэртэй хахууль өгөх ёсгүй. Гэвч, хувийн цэцэрлэгт сарын 150-200 мянгыг төлж байснаас улсынх нь цэцэрлэгт нэг удаадаа “хандив” өгөөд, сургуульд ортлоо хүмүүжих боломжтой гэж сэтгэсний үндсэн дээр эцэг, эхчүүд цэцэрлэгийн эрхлэгчийн өрөөг сахиж суугаа сурагтай. Хандив нэртэй хахууль төвийн буюу томоохон хотхонууд дунд байрлах харьяаллын хүүхэд олонтой цэцэрлэгт 500 мянга төгрөг байдаг бол захын цэцэрлэгүүдэд 150-200 мянган төгрөг байдаг гэнэ. Энэ тоо 2011 оны үед 20-50 мянган төгрөгний хооронд хэлбэлзэж байжээ. Цэцэрлэгийн хүрэлцээ муу учраас одоогоор сугалаанаас өөр шударга шийдэл байхгүй гэдгийг салбар яамнаас мэдэгдэж байгаа. Тэр нь ч үнэн. Өмнө нь хүүхдээ цэцэрлэгт хамруулахын тулд эцэг, эхчүүд наймдугаар сарын дунд үеэс эхлэн харьяа цэцэрлэгүүдийг хаалгыг манаж эхэлдэг уламжлал бараг тогтчихсон байсан. Хөнжил, гудсаа авчирч, цэцэрлэгийн гадна хэдэн өдөр хоноглох тэр бүр хүмүүсийн хүсээд байх зүйл. Тэглээ гээд хүүхдээ гэртээ цоожлохгүйн тулд давах ёстой давааны нэг л байв. Гэтэл үүний хажуугаар дараалалд зогсож зовохгүйгээр хүүхдээ цэцэрлэгт өгчихдөг овсгоотой эцэг, эхчүүд бий. Тэд танил тал, цэцэрлэгийн эрхлэгчийн гарыг хүндрүүлж асуудлаа төвөггүй-хэн шийдчихдэг байсан. Нэг ёсондоо эрэлт нь байхад нийлүүлэлт нь байхаас өөр яалтай. Гэтэл одоо сугалаанд азгүй, азаа үзээд ч хүүхдээ оруулж чадаагүй, эсвэл харьяаллын бус атлаа ажил, гэртээ ойртуулан өнөөх хандив гэгчийг барьж гүйх эцэг эхчүүд олширчээ. Харин эсрэгээр гар хардаг цэцэрлэгийнхний тоо нэмэгдэн, арга нь улам бүр нарийсч, тариф хүртэл тогтоосон байх жишээтэй. Хэдийгээр төр, хүүхдүүдийг алагчлахгүйн тулд цахим бүртгэл, сугалаа гэсэн аргуудыг санаачилж байгаа ч, үүний ард хандив нэрээр халхавчилсан хахууль байсаар л байна.

# МОНГОЛ УЛС САНХҮҮГИЙН ДАМПУУРЛАА ЗАРЛАХ ГЭЖ БАЙСНЫ НЭГ ЖИЛИЙН ОЙД...

Жилийн өмнө улсын эдийн засгийн нөхцөл байдал ямар байсныг цөөн үзүүлэлтээр эргэн саная. 2016 оны эхний хагас жилд төсөв их наяд төгрөгийн алдагдалтай, эдийн засгийн өсөлт саарч, сүүлийн таван жилд ДНБ анх удаа хасах утгатай гарч байв. Гадаад хөрөнгө оруулалт тэгтэй тэнцэж, төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2500 давж, үндсэндээ Монгол Улс олон улсаас босгосон зээлээ төлж чадахгүй дефольтоо зарлах хэмжээнд хүрсэн гэдгийг шинжээчид тодотгож байлаа.

> ...Засгийн газар огцорсноор улстөрийн тогтворгүй байдал гаарч, эдийн засаг хямарсан гашуун туршлагыг бүгд мартаагүй. Тухайлбал, 2012-2014 онд Н.Алтанхуягийн Засгийн газрын үед манай улсын эдийн засаг 11 хувийн өсөлттэй байв. Харин Н.Алтанхуягийн Засгийн газрыг Ч.Сайханбилэгийнхээр сольсны дараа буюу 2014 оны эцэст улсын эдийн засаг 11 хувиас 7.8 хувь болж огцом унасан...

Тэгвэл өнөөдөр ямар өөрчлөлт гарсан бэ. 2017 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын эдийн засаг 4.2 хувийн өсөлттэй гарав. Төсвийн алдагдал 740 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 383 тэрбум төгрөгөөр буурчээ. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2400 төгрөгт тогтвортой, он гарсаар 200 гаруй сая ам.долларын гадаад шууд хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил идэвхиж, нүүрсний олборлолтын хэмжээ огцом өсч, экспортын орлого тав дахин нэмэгдэв. Жилийн өмнө Засгийн газар хүүхдийн мөнгөө ч өгөх санхүүжилтгүй байсан бол өнөөдөр төсвийн орлого 579 тэрбум төгрөгөөр давсан дүнтэй гарч, улсын төсвөөр хасч байсан хүүхдийн мөнгөө бүх хүүхдэд эргэн олгож эхэлжээ.

Энэ бүхэн нэг жилийн дотор манай улсын эдийн засагт ахиц гарсныг илтгэнэ. Энэ нь бодит эдийн засгийн орчин гэхээс илүүтэйгээр улс төрийн тогтвортой байдлаас үүдэлтэй өөрчлөлт гэдгийг эдийн засагчид тодорхойлсон. Учир нь, манай эдийн засаг улстөрийн нөхцөл байдлаас шууд хамааралтай. Эрх баригч намын улс төрийн шийдвэр, нөлөө бүхий улстөрчдийн мэдэгдлийн нөлөөгөөр эдийн засаг дахь үзүүлэлтүүд савладаг. Тухайлбал, УИХ-д МАН 65 суудал авч, Засгийн газар танхимаа бүрдүүлсний дараа дотоодод долларын ханш суларч, гадаад зах зээлд томоохон компаниудын хувьцааны ханш өсч байх жишээний.

Яг жилийн өмнө эрх баригч намынхан эдийн засгийн хүндрэлийг дотоод хүчин чадлаар давж чадахгүй гэдэгт санал нэгдэж, ОУВС-гаас тусламж хүссэн.

Засгийн газар бүрдсэн даруйдаа ОУВС-д хандсан нь үүнийг гэрчилнэ. Засгийн газар Валютын сангийн найман сар үргэлжилсэн хэлэлцээр амжилттай өндөрлөж, тавдугаар сарын 23-наас манай улсад ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжих шийдвэр гарсан билээ. Энэ үйл явц нь эргээд олон улсын зах зээлд Монгол Улсын эдийн засаг сэргэх эерэг мессеж болсон. Дотоодын эдийн засагчид ч Валютын сангийн хөтөлбөрт хамрагдсан нь зөв зүйтэй алхам болсныг тодотгож байв. Нөгөө талд бодлого тогтвортой хэрэгжих улс төр болоод эдийн засгийн нөхцөл бүрдсэн гэж хөрөнгө оруулагчид итгэсэн. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад тогтвортой бодлого хэрэгжиж, төсөв, санхүүгийн сахилга баттай болно гэж хөрөнгө оруулагчид итгэж буй. Товчхондоо, өнгөрсөн нэг жил эдийн засагт гарсан өөрчлөлт энэ.

Харин сүүлийн үеийн улстөрийн нөхцөл байдал эдийн засгийн өсөлтийг хязгаарлах, хөрөнгө оруулагчдын итгэлийг хөсөрдүүлж магадгүй боллоо. Ерөнхийлөгчийн сонгуулийн дараах эрх баригч намын дотоод талцал, өнөөгийн Засгийн газрыг огцруулах талаарх мэдээ гадаад, дотоод орчинд сөргөөр нөлөөлж эхлээд байна. Бизнес эрхлэгчид 2013 он шиг улстөрийн ойлгомжгүй байдал үүсэх вий гэсэн болгоомжлол, шинэ төсөл хөтөлбөрөө эхлэхээ азнаж, хүлээлтэд оржээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-ын нам ялалт байгуулж чадаагүй. Хэлсэн үг, үзэл баримтлал нь хөрөнгө оруулагчдын эрх ашигтай харшилддаг АН-ын нэр дэвшигч Х.Баттулга Ерөнхийлөгч болсон нь зарим нэг талаараа хөрөнгө оруулагчдыг эргэлзэхэд хүргэж байсан. Гэтэл дарин дээр давс гэгчээр Ерөнхийлөгчийн сонгуулийн дараах эргэлзээн дээр эрх баригч намын улс төрийн ойлгомжгүй байдал нь сэргэж буй эдийн засгаа буцаагаад унагааж мэдэх л юм.

МАН-ын дотоод улс төр даамжирч, Засгийн газраа огцруулах тухай яриа хүчээ авч байна. Монголын улс төрд Засгийн газраа огцруулж байсан түүх олон бий. Харамсалтай нь, Засгийн газар огцорсноор эдийн засаг сэргэж, өсч байсан түүх нэг ч байхгүй. Харин Засгийн газар огцорсноор улстөрийн тогтворгүй байдал гаарч, эдийн засаг хямарсан гашуун туршлагыг бүгд мартаагүй. Тухайлбал, 2012-2014 онд Н.Алтанхуягийн Засгийн газрын үед манай улсын эдийн засаг 11 хувийн өсөлттэй байв. Харин Н.Алтанхуягийн Засгийн газрыг Ч.Сайханбилэгийнхээр сольсны дараа буюу 2014 оны эцэст улсын эдийн засаг 11 хувиас 7.8 хувь болж огцом унасан. Цаашлаад Монгол Улсын эдийн засаг 2015 оны эцэст 2.5 хувь, 2016 онд өсөлтгүй болсон. Засаг солигдсоны дараа гадаад шууд хөрөнгө оруулалт хоёр тэрбум ам.доллараас 110 сая болтлоо буурч, хоёр компани тутмын нэг нь үйл ажиллагаагаа зогсоож, үүний уршгаар олон мянган иргэн ажилгүй болсон. Сайнаасаа илүү саар үр дүн олонтаа гарчээ.

Энэ алдааг дахин давтах эрх 65-ын бүлэгт байхгүй. Засаг солигдсоноор эдийн засаг сайжрах биш, харин ч мууддаг гэдгийг өмнөх туршлагаас харагдаж байна.

Улс төрийн тогтворгүй байдлыг дагаж эдийн засаг болон зах зээлийн таатай байдал л алдагдагдана. Өнөөгийн ашигт малтмалын түүхий эдийн ханшийн таатай байдал удаан үргэлжлэхгүй энэ үед улс төрийн тогтворгүй байдал зах зээлийг улам муутгана. Ерөнхийлөгчийн сонгуулийн дараах эргэлзээн дээр улс төрийн тогтворгүй байдал нэмэрлэж манай улсын гол худалдан авагч БНХАУ-ын ойлгомжгүй байдал үргэлжилнэ. Энэ нөхцөлд манай гол нэрийн бүтээгдэхүүн зэс, нүүрс худалдан авагчгүй болно, төсвийн орлого тасалдана. Эргээд 2014-2016 оных шиг төсвийн өндөр алдагдал, тогтвортой бодлогоос үүдэлтэй эдийн засгийн хүндрэлүүд үүснэ. Цаашлаад одоогийн хэрэгжиж буй Валютын сангийн хөтөлбөр чангарах, хандивлагч байгууллагуудаас санхүүжилтээ зогсоох хүртэл эрсдэл учирч мэднэ.

Учир нь, валютын сангийн хөтөлбөрийн хамгийн гол зорилго нь тогтвортой байдлыг бий болгох юм. Төсвийн алдагдлыг үе шаттай бууруулж, төрийн оролцоог багасгаж, банк санхүүгийн тогтвортой байдлыг бэхлүүлэхэд оршиж буй. Харин Засгийн газраа огцруулсан улс төрийн тогтворгүй байдал эдийн засагт шууд нөлөөлөх учраас хөтөлбөр чангарах магадлалтай гэсэн үг. Учир нь, Засгийн газар болон улстөрчид Валютын сангийн шаардсан нөхцөлийг зөрчсөн тохиолдолд дараагийн санхүүжилтийг зогсоох, түдгэлзүүлэх бүрэн эрхтэй билээ. Үүний тод жишээ нь Египет, Украинаас харж болно. Украин анх Стэнд бай хөтөлбөрт хамрагдаж, таван тэрбум ам.долларын зээл авсан ч улстөрийн тогтворгүй байдал гаарч, хөтөлбөрөөр тохирсон үр дүнд хүрээгүй болохоор дараагийн шатны урт хугацаатай, хатуу хөтөлбөрөөр сольсон билээ. Монгол Улс үүнийг давтахгүй гэх баталгаа алга.

Монголд үе үеийн эрх баригчид эдийн засаг биш, улс төрөө ямагт нэгд эрэмбэлж, улстөрийн тогтворгүй байдлыг бий болгож эдийн засгаа унагаадаг нь нь харамсалтай. Зүй нь нэгд, эдийн засаг, хоёрт улс төр эрэмбэлэгдсэн цагт Монголын тогтвортой хөгжиж чадна. Монгол Улс санхүүгийн дампуурлаа зарлах гэж байсны нэг жилийн ой энэ өдрүүдэд болж байна. Ойн баярын бэлэг болгож МАН-ын зарим гишүүд “эргээд жилийн өмнөх рүүгээ очъё, эсвэл Украйн, Египет шиг эдийн засгаа самрах санал” санал гаргаж байна.


Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

# МЭДЭЭЛЭЛ

Food and Agriculture Organization of the United Nations

## АЖЛЫН ЗАР No:A3-GCP/MON/014/EC-A3

**АЛБАН ТУШААЛ:** Төслийн орон нутгийн зохицуулагч
**Нийтэлсэн огноо:** 2017-н оны 08-р сарын 15
**Анкет авах сүүлийн огноо:** 2017-н оны 08-р сарын 25

**ТӨСЛИЙН НЭР/КОД:** *“Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх нь (SECiM) Бүрэлдэхүүн хэсэг 2: Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл GCP/MON/014/EC*

**БАЙРЛАЛ:** СЭЛЭНГЭ АЙМАГ **ГЭРЭЭТ ХУГАЦАА:12 сар (сунгах боломжтой, туршилтын хугацаатай)**

**БАЙГУУЛЛАГА:** НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага

НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага (ХХААБ) Европын Холбооны санхүүжилттэй“Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх нь: Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл”Сэлэнгэ аймагт төслийн Орон нутгийн зохицуулагч сонгон шалгаруулж авна.

НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага болон төслийн техникийн багийн удирдлагад ажиллах Орон нутгийн зохицуулагчийн гүйцэтгэх үндсэн үүрэг нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газар, хүнс хөдөө аж ахуйн газар, эрдэм шинжилгээ, хувийн хэвшлийн байгууллага болон бусад оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж, төслийг амжилттай хэрэгжүүлэх;
2. Жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хагас жил тутам явцын тайлан, сар бүр санхүүгийн тайлан гаргах;
3. Аймгийн Засаг даргын тамгын газар болон SECiM төслийн удирдлагын хэлэлцэж тохирсон асуудлыг хэрэгжүүлэх Үүнд:
    - Аймгийн нэмүү өртгийн сүлжээний маркетинг, стратегийг хөгжүүлэх,
    - Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний болон хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээний эдийн
    - засгийн загвар бий болгох, хэрэгжүүлэх (ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр)
    - Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор төслийн дэд бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нэмүү өртгийн сүлжээний платформ буюу индэр байгуулж, хамтран ажиллах, бэхжүүлэх
4. Төслийн уулзалтуудыг зохион байгуулах, зайны сургалтыг дэмжиж ажиллах, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоох, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, төлөвлөлт хэрэгжилтэд ашиглах.
5. Төслийн хүрээнд зайны сургалт зохион байгуулах, онлайн сургалт хийхэд туслалцаа үзүүлэх;
6. Аймагт ажиллах олон улсын болон үндэсний зөвлөхүүдэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах
7. Орон нутагт зарцуулагдах төсвийн зарцуулалтыг НҮБ-ын ХХААБ-ын дүрэм, журмын дагуу зохион байгуулах;
8. Төслийн хяналт, үнэлгээнд шаардагдах мэдээллийг төслийн төлөвлөгөөтэй уялдуулан цуглуулах, тайлагнах
9. НҮБ-ын ХХААБ болон төслийн багийг орон нутагт төслийн үйл ажиллагааны хэрэгжилттэй холбоотой гарч буй боломж, тулгарч буй бэрхшээлийн талаарх мэдээллээр хангах, шийдвэрлэх арга замуудыг санал болгох
10. Төсөл хэрэгжиж буй бусад аймгууд болон аймгууд дахь төслийн Орон нутгийн зохицуулагч нартай үйл ажиллагаагаа уялдуулж, хамтран ажиллах
11. Төсөл амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад үйл ажиллагааг төслийн удирдлагатай хамтарч гүйцэтгэх, санаачлан хэрэгжүүлэх

**АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- Бизнесийн удирдлага, эдийн засаг, маркетингийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Бизнес, эдийн засаг, маркетингтай холбоотой ур чадваруудыг маш сайн эзэмшсэн байх
- Хүнс, хөдөө аж ахуй, бизнесийн байгууллагад бизнес, эдийн засгийн салбарт хамгийн багадаа5 жил ажилласан туршлагатай байх
- Мэргэжлийн хувьд болон багаар ажиллах чадвартай, уян хатан байх, үүнд мэргэжлийн ёс зүй, харилцааны өндөр соёлтой, хүлээцтэй, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй, хувийн зохион байгуулалт сайтай, төлөвлөгөө боловсруулах, ажил үүргийг зөв хуваарилах, цагийг үр ашигтай ашиглаж чаддаг байх
- Англи хэлний дунд түвшний мэдлэгтэй,
- Монгол хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэг, ур чадвартай байх
- Компьютерийн хэрэглээний программуудыг (Word, Excel, Access, PowerPoint, Outlook гэх мэт) мэргэжлийн түвшинд эзэмшсэн байх

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ**

Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй хүмүүс НҮБ-ын ХХААБ-ын анкетыг (FAO Personal Profile Form (PPF)) http://www.fao.org/employment/irecruitment-access/en/сайтнаас татан авч бөглөн холбогдох тодорхойлолтуудын хамт secim-registry@fao.org хаяг руу илгээж, эх хувийг Сэлэнгэ аймгийн Засаг Даргын Тамгын Газрын (ЗДТГ) бичиг хэрэгт бүртгүүлэн хүлээлгэж өгнө үү.

Холбогдох бичиг баримтуудаа аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн бол энэ талаар secim-registry@fao.orgхаягаар давхар мэдэгдэнэ.

Хэрэв Улаанбаатар хотод байгаа бол мөн өөрийн биеэр ХХААХҮЯ-ны 9А байрны 103 тоот төслийн төв нэгжид авчирч өгнө үү.

Холбоо барих: 08:30-17:30 цагийн хооронд 70150078 дугаарын утсаар холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

Урьдчилсан сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажил горилогчдыг ажлын ярилцлагад урих болно.

**АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

- Бизнесийн удирдлага, эдийн засаг, маркетингийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Бизнес, эдийн засаг, маркетингтай холбоотой ур чадваруудыг маш сайн эзэмшсэн байх
- Хүнс, хөдөө аж ахуй, бизнесийн байгууллагад бизнес, эдийн засгийн салбарт хамгийн багадаа5 жил ажилласан туршлагатай байх
- Мэргэжлийн хувьд болон багаар ажиллах чадвартай, уян хатан байх, үүнд мэргэжлийн ёс зүй, харилцааны өндөр соёлтой, хүлээцтэй, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй, хувийн зохион байгуулалт сайтай, төлөвлөгөө боловсруулах, ажил үүргийг зөв хуваарилах, цагийг үр ашигтай ашиглаж чаддаг байх
- Англи хэлний дунд түвшний мэдлэгтэй,
- Монгол хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэг, ур чадвартай байх
- Компьютерийн хэрэглээний программуудыг (Word, Excel, Access, PowerPoint, Outlook гэх мэт) мэргэжлийн түвшинд эзэмшсэн бай

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ**

Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй хүмүүс НҮБ-ын ХХААБ-ын анкетыг (FAO Personal Profile Form (PPF)) http://www.fao.org/employment/irecruitment-access/en/сайтнаас татан авч бөглөн холбогдох тодорхойлолтуудын хамт secim-registry@fao.org хаяг руу илгээж, эх хувийг Сэлэнгэ аймгийн Засаг Даргын Тамгын Газрын (ЗДТГ) бичиг хэрэгт бүртгүүлэн хүлээлгэж өгнө үү.

Холбогдох бичиг баримтуудаа аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн бол энэ талаар secim-registry@fao.orgхаягаар давхар мэдэгдэнэ.

*Хэрэв Улаанбаатар хотод байгаа бол мөн өөрийн биеэр ХХААХҮЯ-ны 9А байрны 103 тоот төслийн төв нэгжид авчирч өгнө үү.*
*Холбоо барих: 08:30-17:30 цагийн хооронд 70150078 дугаарын утсаар холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.*
*Урьдчилсан сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажил горилогчдыг ажлын ярилцлагад урих болно.*

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТУЗ-Д АЖИЛЛАХ ОЛОН НИЙТИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

*Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.23 дахь заалт болон Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/189 дугаар тушаалын дагуу орон нутгийн өмчит Нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах гэж байна.*

**Дээрх сонгон шалгаруулалтанд:**

- Даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллага,
- Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага
- Эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөл өөрсдийн эрх барих байгууллагын баталгаажуулсан нэг хүнийг нэр дэвшүүлэх боломжтой юм.

**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

1. Сүүлийн зургаан сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байх
2. Тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй байх
3. Санхүүгийн зөрчилгүй байх

**НЭР ДЭВШИГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

1. Тухайн эмнэлэгтэй ашиг сонирхлын зөрчилгүй байх
2. Нийгмийн эрүүл мэнд болон анагаах ухааны боловсролтой, эсхүл эрх зүй, эдийн засаг, удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр мэргэшсэн, эрүүл мэндийн салбарт ажилласан туршлагатай
3. Улс төрийн намын удирдах, орон тооны болон сонгуульт ажил эрхэлдэггүй
4. Бусад эрүүл мэндийн байгууллагад хөрөнгө оруулалт хийгээгүй

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ:**

**Дээрх шаардлагыг хангасан гишүүн:**

- Өргөдөл
- Төрийн албан хаагчийн анкет
- Дипломны хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Харьяа байгууллагын тодорхойлолт
- Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар
- Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл / УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралт/
- Өр, төлбөргүй тодорхойлолт /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, татварын газраас тодорхойлолт/

**Төрийн бус байгууллагын гишүүн нэмэлтээр:**

- Байгууллагын сүүлийн нэг жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланг тус тус бүрдүүлэн 2017 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын 116 тоот өрөө, эрүүл мэнд, спортын асуудал хариуцсан мэргэжилтэнд ирүүлнэ үү.
- Холбоо барих 95552435

*Жич: Хар нүүрэнд нэг удаа 4/1 хэмжээгээр гаргана.*
*Нэхэмжлэлийг бичихдээ ХААНА гэдэг дээр: Сэлэнгэ аймгийн ЗДТГ дахь Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-д ажиллах олон нийтийн төлөөллийг сонгон шалгуурах хороо*

## НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНД УРЬЖ БАЙНА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 128 дугээр тогтоолд заагдсан дараах хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар

| Д/д | Байгууллагын нэр | Хөрөнгийн нэр, марк, улсын дугаар | Ашиглалтанд орсон он | Худалдах доод үнэ / мян.төг/ | Дэнчин / мян.төг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | ШШГЕГ-ын харъяа хориг 435-р анги | УАЗ-220692-033 маркийн 48-35 ДАР | 2009 | 1,000.00 | 250.0 |

**Дуудлага худалдаанд оролцох хүсэлт ирүүлэх:**

- Дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө ирүүлнэ.
- Дуудлага худалдаанд оролцох хүсэлт нь зөв, цэвэр бөглөсөн худалдаанд оролцох хүсэлтийн маягт, дэнчин төлснийг нотлох баримт, иргэний үнэмлэх /аж ахуйн нэгжийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ /-ний нотариатаар батлуулсан хуулбар зэрэг баримтаас бүрдэнэ. Бүрдүүлсэн баримтаа дугтуйнд хийж битүүмжилсэн байна.

**Дуудлага худалдааны дэнчин:**

- Худалдах доод үнийн 25%-тай тэнцэх тэнцэх төгрөгийг бэлнээр өөрийн байранд авчирч тушаана
- Холбоо барих Утас: 99178246

**ШШГЕГ-ЫН ХАРЪЯА ХОРИГ 435-Р АНГИ**

## АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

सत्यमेव जयते

Дараах шаардлагуудыг бүрэн хангасан хүнийг МАРКЕТИНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ-ын бүрэн цагийн ажлын байранд өргөдлөө гаргахыг Энэтхэгийн Элчин сайдын яам урьж байна:-

1. Хамгийн багадаа Худалдаа/Эдийн засаг/ Бизнесийн удирдлагаар Мастерын зэрэгтэй.
2. Өндөр хэмжээний бичгийн орчуулгын болон ойлгох ур чадвар бүхий Англи, Монгол хэл (ярианы болон бичгийн аль алинийг нь)-ийг өндөр түвшинд эзэмшсэн.
3. Компьютерийн маш сайн мэдлэгтэй, фейсбүүк, твиттер зэрэг нийгмийн харилцааны хэрэгсэл ашиглах, хэрэглэх чадвартай.
4. Өнөөгийн байдлаар 25 нас бүрэн хүрсэн.
5. Удирдах түвшний ажлын туршлагатай, бие даасан худалдааны илтгэл бэлтгэх, бизнесийн хамт олонтой харилцан маркетингийн судалгаа хийх чадвар чухал тал болно.
6. Элчин сайдын яамд/ Олон талт хамтын ажиллагаатай байгууллага зэрэг Дипломат байгууллагад ажилласан туршлагатай.
7. Энэтхэг эсвэл аль нэг аль англи хэлтэй оронд боловсрол эзэмшсэн болон/ эсвэл ажилласан туршлагатай бол давуу тал болно.

Зөвхөн шаардлага хангасан өргөдөл гаргагчийг Шалгалт болон Ярилцлагат урих болно.

Өргөдлөө товч намтрын хамт 2017-09-15 (Баасан гараг)-ны 1700 цагт багтаан доорх э-мейлээр илгээнэ үү: admn.ulaan@mea.gov.in.

**АНХААР: УЛААНБААТАР ДАХЬ ЭНЭТХЭГИЙН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ ЯМАР Ч ӨРГӨДЛӨӨС ЯМАР НЭГ ТАЙЛБАРГҮЙ ТАТГАЛЗАХ ЭРХТЭЙ**

# ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронд

# “60 ТЭРБУМ”-ЫН ХЭРГИЙГ ӨӨРСДӨӨ НОТОЛЧИХОЖ БАЙГАА ЮМ БИШ ҮҮ

Өнгөрсөн 2016 оны зургадугаар сард буюу УИХ-ын сонгуулийн сурталчилгааны үеэр МАН-ын удирдлагууд болох М.Энхболд, нийслэлийн МАН-ын дарга Ц.Сандуй, түүний туслах А.Ганбаатар нарын нэгэн ноцтой бичлэг цацагдаж, олны анхаарлыг татаж байсан билээ. Тодруулбал, тэдний төрийн албан тушаалыг үнэлэн 60 тэрбум төгрөг босгох тухай ярилцаж байгаа дуу хоолой нь ил болж, хэсэгтээ л шуугиан дэгдээсэн. Тухайн үед энэхүү бичлэгийг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Э.Эрдэнэжамъянг олон нийтэд цацаж, нэр хүндэд нь халдсан гэх үндэслэлээр НИТХ-ын Ц.Сандуйн хуулийн зөвлөх А.Ганбаатар гэгч нь шүүхэд өгч байв. Гэтэл Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр бүр ч ноцтой бичлэгүүд цацагдаж, өнөөдөр энэ асуудал нийт монголчуудын анхааралд өртөөд байна. Үнэндээ алдарт “60 тэрбум”-ын бичлэгийг олон нийтэд ил болгосон хүн нь Г.Доржзодов гэх залуу бөгөөд иргэдэд үнэн зөв мэдээллийг өгөх үүднээс МАН-ын удирдлагуудын 90 минутын бичлэг хэзээнээс эхлэлтэй, чухам юу гэж ярьсан, 60 тэрбумын бичлэгийн асуудлаар хэн хэн юу гэж ярьж мэдэгдэж байсныг он цагийн дараалалтайгаар багтаасан сайт ажиллуулж эхэлсэн гэнэ билээ. Тэгвэл эл хэрэг яг одоо өрнөж, хэрэгт холбогдсон хүмүүс ч дуугарч эхэллээ. Ингээд энэ удаагийн “Онцлох хуудас” булангаа алдарт “60 тэрбум”-ын хэргийн сүүлийн үед өрнөж буй мэдээллийн эргэн тойронд бэлтгэлээ.

### Д.АМАРБАЯСГАЛАН: “60 ТЭРБУМ”-ЫН БИЧЛЭГИЙГ ЭВЛҮҮЛЭГ ГЭЖ БОДОЖ БАЙСАН Ч Ц.САНДУЙ ҮНЭНЭЭ ХЭЛСЭН

**2017.08.18:** Энэ хэргийн гол эзэн гэгддэг НИТХ-ын дарга Ц.Сандуйн зөвлөх А.Ганбаатар мэдээлэл хийхдээ Шадар сайд У.Хүрэлсүх, МАН-ын генсек Д.Амарбаясгалан, УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нар уулзалт хийсэн, бид байгаагүй хэмээн ярьсан. Үүний дараа МАН-ын генсек Д.Амарбаясгалан АТГ-т энэ талаар мэдүүлэг өгсөн юм. Тэрбээр орохынхоо өмнө “60 тэрбумын асуудал нийгмийн бухимдуулж байна. Энэ хэргийн хамгийн том хохирогч нь МАН болоод нийт гишүүд. Зарим гишүүд энэ асуудлаас болоод уурлаж, бухимдаж, айж, ичиж байна. Тиймээс энэ асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай. Өчигдөр А.Ганбаатар гэдэг хүн мэдээлэл хийж, энэ асуудлыг ярьж байхад Д.Амарбаясгалан нарын хүмүүс байсан мэтээр ярьж, олон нийтийг төөрөгдүүллээ. Хүмүүсийн энэ цайрсан үйлдэлд их харамсаж байна. Би өнөөдрийг хүртэл 60 тэрбумын асуудлыг эвлүүлэг гэж бодож ирсэн. 2016 оны үед анх бичлэг цацагдахад нэр холбогдсон нөхдүүд “эвлүүлэг” гэж мэдэгдсэн. Мөн Сүхбаатар дүүргийн цагдаагаас “энэ бичлэг эвлүүлэг” гэсэн албан тоотыг манай намд ирүүлсэн байсан. Харамсалтай нь саяхан болсон МАН-ын Удирдах зөвлөлийн хурал дээр НИТХ-ын дарга Ц.Сандуй “Ийм үйл явдал бодитой болсон” хэмээн хүлээн зөвшөөрсөн. Тиймээс өнгөрсөн хугацаанд энэ бичлэгийн эвлүүлэг хэмээн мэдэгдэж байсандаа харамсаж байна. Өчигдөр А.Ганбаатар гэдэг хүн 60 тэрбум төгрөг босгох талаар ярилцсан уулзалтад Д.Амарбаясгалан байсан мэтээр мэдэгдсэн учир өнөөдөр АТГ-ынхан надаас мэдүүлэг авахаар дуудлаа. Сайн байна. АТГ их хурдтай ажиллаж байна. Үнэнийг хэлэхэд би 2014 онд болсон гэх энэ уулзалт яриа хэлэлцээрийн үед огт байгаагүй. Тухайн үед би АНУ-д сурч байсан. Үүнийг намын нөхөд болсон НИТХ-ынхан бүгд мэдэж байгаа. Тэгээд ч би иймэрхүү яриа хэлэлцээрт ордоггүй. Би НИТХ-ын төлөөлөгчөөр гурав дахь удаагаа сонгогдсон. Энэ асуудал бол МАН-ын мянга мянган гишүүдийн эрх зүйн асуудал. Тиймээс надад энэ асуудлыг хаагаад байх ёс зүйн асуудал байхгүй. Би Ц.Сандуйг огцрох ёстой гэж үзэж байна. Иргэн Ц.Сандуй болж хууль хяналтынхаа байгууллагуудаар явж асуудлаа шийдээсэй гэж хүсч байна. Учир нь үүний цаана МАН-ын нийт гишүүдийн нэр төр явж байгаа. МАН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд намынхаа эв нэгдлийг хангаж ажиллах үүргээ ухамсарлаж байгаа. Энэ талаар УЗ-ийн хурал дээр ч хэлсэн. Гэхдээ өнгөрсөн хугацаанд миний болоод бусад гишүүдийн нэр төрд халдсан олон зохимол бичлэг, мэдээллүүд гарсан. Үүнийг хийсэн Удирдах зөвлөлийн гишүүнийг мэдэж байгаа учир хэвлэлээр янз бүрийн юм яриагүй. Ярьдаг газар нь ярина. Энэ бол намын Бага болоод Их хурал. Сүүлийн үед Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр намынхаа эсрэг ажилласан гэж ярьж буй хүмүүс бий. Энэ намд итгэл үнэмшилээ өгч, удирдлага чиг үүргийг нь манлайлан удирдан чиглүүлж явна гэж зүтгэснээсээ хойш намынхаа эсрэг нэг зүйл бодож яваагүй. Магадгүй зарим нэг хүнтэй үзэл бодол таарахгүй, эрх ашиг нь нийлэхгүй болохоор иймэ зүйл ярьсан байх. Мөн МАН-ын гишүүн иргэн А.Ганбаатарыг нэр төрд халдсан хэмээн шүүхэд хандахаар болсон” гэв.

### 3000 ГАРУЙ ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНААС МЭДҮҮЛЭГ АВНА

**2017.08.14:** Нийслэлийн МАН-ын дарга, НИТХ-ын дарга Ц.Сандуй 2016 оны сонгуулийн өмнө төрийн албыг “наймаалцаж” 60 тэрбум төгрөг намдаа босгох тухай асуудлыг ярьсан нь олон нийтэд ил болж, өөрөө ч ам алдан зөвшөөрснөөр нийгэмд ихээхэн маргаан шүүмжлэл дагуулсан билээ. Энэхүү асуудал энгийн иргэдээс эхлээд төр засгийн анхаарлын төвд байж, шалгахыг шаардах болсноор энэхүү МАН-ын удирдлагуудын төрийн албан хаагчдаас босгохоор төлөвлөсөн 60 тэрбум төгрөгтэй холбоотой асуудлаар АТГ-аас эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн. Тэгвэл энэ асуудлын хүрээнд төрийн өндөр албан тушаалд очихдоо авлига өгсөн байж болзошгүй гэсэн үндэслэлээр нийт 3000 гаруй төрийн өндөр албан тушаалтнуудыг АТГ-аас мэдүүлэг авч эхэлжээ. Тодруулбал, нийслэлийн Засаг даргаас эхлүүлээд агентлагийн дарга, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн хүртэлх албан тушаалтнуудаас мэдүүлэг авах юм байна. Хуулийнхан албан тушаалтнуудаас хэрхэн ажилд томилогдсон, авлига өгсөн эсэхийг өөрсдөөс нь тодруулж буй юм. Энэ хэрэгт НИТХ-ын дарга бөгөөд нийслэлийн МАН-ын дарга Ц.Сандуй, түүний зөвлөх А.Ганбаатар нарт эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа гэсэн мэдээлэл байна.

### М.ЭНХБОЛД: Ц.САНДУЙГ ОГЦРУУЛАХ ҮНДЭСЛЭЛГҮЙ, 60 ТЭРБУМ БОЛ ЭВЛҮҮЛЭГ

**2017.08.16:** МАН-ын Удирдах зөвлөл энэ өдөр хуралдаж, 60 тэрбумын схем тойрсон асуудлыг хэлэлцсэн ч намын дарга М.Энхболд, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат нар 60 тэрбумын бичлэг бол эвлүүлэг учраас Ц.Сандуйд хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй гэж үзжээ. Энэ үед бухимдсан Шадар сайд У.Хүрэлсүх М.Энхболд, Ж.Эрдэнэбат нарт хандан чаддаг юм бол бүгдээрээ ажлаа өгч байгаад асуудлаа шийдье гэж хэлсэн талаар эх сурвалжууд мэдээлж буй. Түүнчлэн УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж мөн намын удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрохыг шаардсан байна.




### А.ГАНБААТАР: УУЛЗАЛТ БОЛСОН, ТЭГЭХДЭЭ БИД БАЙГААГҮЙ

**2017.08.17:** Төрийн албыг 60 тэрбум төгрөгөөр арилжихыг завдсан хэрэгт холбогдоод байгаа МАН-ын гишүүн, “Шинэ Монгол хаадууд” группын захирал А.Ганбаатар хэвлэлийн хурал зарлаж, сэтгүүлчдэд мэдээлэл өгөв. Тэрбээр “Би бол МАН төрийн албан тушаалыг зарж борлуулан 60 тэрбум төгрөг босгох гэсэн асуудалд холбогдоод байгаа А.Ганбаатар гэж хүн байна” хэмээн өөрийгөө танилцуулахаас яриагаа эхэлсэн бөгөөд 60 тэрбумын асуудал бол улс төрийн зорилгоор сонгууль дөхөхөд гаргаж тавьсан, Г.Доржзодов гэдэг хүний хийсэн эвлүүлэг гэсэн юм. Мөн “Миний бие нийслэлийн МАН-ын хорооны дарга Ц.Сандуйн зөвлөхөөр ажилладаг. Жил гаруйн хугацаанд хууль хяналтын байгууллагад тайлбар мэдүүлэг өгсөн. Дээрх газруудаас хэрэг шалгаж байх үед хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хандах хэрэггүй гэсэн учраас мэдээлэл өгөх боломжгүй байлаа. Харин одоо энэ байдал хэрээс хэтэрсэн учраас өнөөдөр бодит байдлыг хэлэхээс өөр аргагүй болж байна. Г.Доржзодов өөрийнхөө хийсэн санхүүгийн схемийг бидэнд санал болгож надтай хэд хэдэн удаа уулзсан. “Та дарга нартаа танилцуулаад, зөвөөр ойлгуулаад өгөөч. Энэ схем ОХУ-д хэрэглэгддэг. 2012 онд АН хэрэглэсэн. 2016 онд хүчтэй сонгууль болно. Танай нам үүнийг ашиглабал ялах магадлал өндөр” гэж байсан юм. Гэтэл одоо өөрийнхөө хийсэн юмыг биднийг хийсэн болгоод олон удаагийн уулзалтын бичлэгийг нийлүүлээд эвлүүлэг хийсэн байна. Санхүүгийн схемийг надад олон удаа танилцуулсан мөртлөө одоо надад тийм мэдлэг чадвар байхгүй гэж яриад байгаа. Үнэндээ Г.Доржзодов татварын ерөнхий газарт даргаар газар хэлтэст нь ажиллаж байсан. Нэр дэвшигчийн зөвлөхөөр ажиллаж, намд тодорхой албан тушаал хашиж байсан юм билээ. Надад CV нь бий. Г.Доржзодов үнэхээр шударга хүн юм бол уулзалтад оролцсон бүх хүмүүсийн бичлэгийг гаргаж ирэх хэрэгтэй. Гэтэл Г.Доржзодовын өөрийнх нь дуу хоолой яагаад байдаггүй юм бэ” хэмээсэн юм. Харин ямар нэгэн уулзалт болсон эсэх талаар асуусан сэтгүүлчийн асуултад тэрбээр “Шинэ Монгол хаадууд” группын дөрөвдүгээр давхар уулзалт болсон нь үнэн. Гэхдээ тэр хурал уулзалтад МАН-ын дарга М.Энхболд, нийслэлийн МАН-ын дарга Ц.Сандуй нар байгаагүй. Нийслэлийн МАН 2016 оны сонгуульд хэрхэн оролцох талаархи төлөвлөгөөг ярихад Шадар сайд У.Хүрэлсүх, МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан, УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нар байсан. Гэтэл эдгээр хүмүүс яагаад өнөөг хүртэл дуугарахгүй, үнэн бодит мэдээллийг өгөхгүй байгаа юм бэ. Би олон жил нөхөрлөсөн Ц.Сандуйтайгаа өнөөдрийг хүртэл уулзаагүй. Намынхаа байраар ч орж чадахгүй явна хэмээсэн юм.

### Ц.НЯМДОРЖ: НААДАХ ЧИНЬ ЭВЛҮҮЛЭГ БИШ, БИ ШУЛУУХАН ХЭЛЧИХЬЕ

**2017.08.17:** МАН-ын Удирдах зөвлөл хуралдах үеэр “60 тэрбум”-ын асуудал яригдаж, намын зарим нөхөд нь удирдлагуудтайгаа санал зөрсөн тул хурлыг орхин гарсан талаар өмнө нь мэдээлсэн. Тэгвэл тэдний нэг нь Ц.Нямдорж гишүүн. Энэ талаар тэрбээр “Удирдах зөвлөлийг хуралдуулж, асуудлаа ярихыг би намын удирдлагуудад хэлсэн. Ингээд Удирдах зөвлөл хуралдах үеэр Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр ажилласан хүмүүст хариуцлага тооцох шаардлагагүй мэтээр яригдаж эхэлсэн тул хурлыг орхин гарсан. Намаа цэгцлэх ёстой зүйлийг л хийх ёстой. Гэтэл удирдаж байгаа хүмүүс нь хойрго хандаад, хариуцлагыг бусад руу чихэх гээд, хариуцлага тооцох ёстой хүмүүсээ өмөөрөөд өмгөөлөөд байгаа аяс харагдахаар нь л гарсан. Үнэндээ 60 тэрбумын асуудал УИХ-ын сонгуулийн үеэр цацагдаж, бид хэсэгтээ л ком-д орсон ш дээ. Хэн ч, юу ч хэлж чадахгүй. Би тэгээд М.Энхболдод хэлсэн “Ц.Сандуйгаа явуул аа. Ийм алхам хийж болохгүй” гэж хэлсэн. Гэтэл Ц.Сандуй ороод ирсэн. Тэгэхээр нь би нүүрэн дээр нь “Чи яв аа” гэж хэлсэн. Гэвч яваагүй. Олонхийн суудал авсан болохоороо НИТХ-ын дарга болгочихсон. Тэгсэн өнөөх асуудал нь дахиад Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр сэдрээд, ард түмэн дургүйцэхэд ихээхэн хэмжээний нөлөө үзүүлсэн. Тэгэхээр нь би дахиад Удирдах зөвлөлийн хурал дээр Сандуйг өргөдлөө өг гэж хэлсэн. Эвлүүлэг энэ тэр гээд л юм ярьж байна билээ. Наадах чинь эвлүүлэг биш, би шулуухан хэлчихье. А.Ганбаатар ярьж, Ц.Сандуй дэмжиж, М.Энхболдод орж танилцуулсан байгаа юм. Тэр эвлүүлэг гэдэг чинь Нямдоржийн хоолойг Чапи дуурайхыг хэлдэг болохоос биш М.Энхболд, Ц.Сандуй хоёрын ярьчихсан яриаг яаж эвлүүлэг гэх юм бэ. Одоо болно. Ийм зүйл ярьсныхаа төлөө зайлах ёстой ш дээ. Улс төрийн наад захын соёл ш дээ. Би нэг их тоодоггүй байсан чинь сая тэр бүрэн эхээрээ цацагдсан бичлэгийг үзсэн чинь огиудас цутгаж байна лээ ш дээ. Тэр А.Ганбаатар гэдэг нөхөр чинь галзуу ч юм уу, согтуу ч юм уу. Ийм хүмүүст хариуцлага тооцох ёстой шүү дээ. Гэтэл ийм хүмүүстээ хариуцлага тооцох талаар ярихаар Удирдах зөвлөл нь урдаас эвлүүлэг гээд гүрийгээд байхаар дургүй хүрнэ ш дээ. Би энэ талаар дахиад ч ярина” хэмээжээ.

Сэтгүүлчийн өнцөг

# ЦАГ АЛДАЖ, ЖОНХУУРАХ ХЭРЭГ Ч АЛГА

Э.ТУУЛ

УИХ-д үнэмлэхүй олонхийн суудал авч, түүндээ эрдсэн МАН-ынхан Ерөнхийлөгчийн сонгуульд хоёр ч удаа өвдөг шороодож, ялагдсан. Унасан бөхөд шалтаг мундахгүй, юу ч гэж ярьж болно. Харин унагасан буруутныг эрж олох гэж МАН-ынхан өнөөдөр хагаралдчихаад сууж байна. Энэ хагаралдаанаас харж болох хамгийн энгийн зүйл бол алдарт “60 тэрбум”-ын хэрэг. Намын удирдлагууд нь эвлүүлэг гэж гүрийсээр... Харин “жараахай”-нууд доогуураа нэг нэгнээ чирж эхэллээ. А.Ганбаатар гэгч алдарт “60 тэрбум”-ын бичлэгт дуу хоолой нь мөнхөрсөн нэг нөхөр гарч ирээд, ах нарыгаа “алаад хаячихлаа”. Бүр М.Энхболд, Ц.Сандуй, бид гурав байгаагүй. Харин Шадар сайд У.Хүрэлсүх, МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан, УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ нар байсан гэж хэлсэн нь ёстой л галын дөлийг өрдсөнтэй ялгаагүй зүйл боллоо. Үүнд нь ундууцсан МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан “60 тэрбум”-ын бичлэгийг эвлүүлэг гэж итгэж байсандаа харамсаж байна. Саяхан болсон намын удирдах зөвлөлийн хурал дээр энэ бичлэгт холбогдсон Ц.Сандуй бичлэг бодит болсон гэдгийг өөрөө хүлээн зөвшөөрсөн учраас эвлүүлэг биш байсан юм байна гэдгийг мэдсэн. Тийм учраас би Ц.Сандуйг огцрох ёстой гэж үзэж байгаа” гээд хэлчихлээ. Бас УИХ-ын гишүүн Ц.Нямдорж “Энэ 60 тэрбумтай холбоотой яриа бол эвлүүлэг биш. Би шулуухан хэлчихье. А.Ганбаатар гэгч ярьсан уу, ярьсан. Ц.Сандуй гэдэг хүн ярьсан зүйлийг нь дэмжсэн үү, дэмжсэн. Дэмжсэнийхээ дараа М.Энхболд дээр орж танилцуулсан. А.Ганбаатар, Ц.Сандуй, М.Энхболд гэсэн гурван хүний л асуудал байгаа шүү дээ. Энэ бол эвлүүлэг биш. Эвлүүлэг гэдэг чинь Нямдоржийн хоолойг Чапи дуурайгаад бичлэг хийхийг хэлдэг болохоос биш М.Энхболд, Ц.Сандуй хоёрын ярьчихсан зүйлийг яаж эвлүүлэг гэж нэрлэдэг юм бэ” гэж ярьж байх юм. Ил хэлж байгаа нь энэ хоёр эрхэм болохоос биш сошиал сүлжээгээр Л.Оюун-Эрдэнэ гишүүнээс эхлээд МАН-ын олон арван хүн “60 тэрбум эвлүүлэг биш бодит болсон явдал” гэдгийг нотлон хэлж байгаа. Гэтэл 2016 ны УИХ-ын сонгуулийн дараагаас эхлэн жил гаруй хугацаанд 60 тэрбумын бичлэгийг эвлүүлэг хэмээж, бодит үнэнийг ард түмнээс нуусан хууль хүчний байгууллагууд, 2016 ны наймдугаар сарын 17-ны өдөр Улсын ерөнхий пркурорын газрын Дотоод аюулгүй байдлын хэлтсийн дарга Э.Амарбатын “60 тэрбумын бичлэг эвлүүлэг байжээ гэдгийг шүүх шинжилгээгээр тогтоолоо” хэмээн албан ёсоор мэдэгдэж байсныг одоо яах ёстой вэ. Үнэндээ 60 тэрбумын хэрэг чинь аль эрт илэрчихээд байгаа юм биш үү, цаг алдах ч хэрэг алга. Түмний нүдэнд ил байгаа хэргийг түргэхэн шийдчихэд яагаад болохгүй гэж. МАН-ынхан ч үнэнд гүйцэгдэж дууслаа. Тиймээс эл хэрэгт холбогдсон нөхдүүд улс төрийн соёл гаргаад, хариуцлагаа хүлээж, өөрсдөө огцорчихвол нэр хүндэд сайнаар нөлөөлөх бус уу. Угтаа бол “60 тэрбум гээд байгаа энэ асуудал эвлүүлэг юм аа. Гэхдээ МАН бол шударга, ёс зүйтэй нам. Ийм асуудал үүссэн бол зөвхөн асуудалтай холбоотойгоор хариуцлага хүлээх чадамжтай улс төрийн хүчин. Тиймээс нийслэлийн МАН-ын дарга Ц.Сандуй миний бие хариуцлага хүлээж албан тушаалаасаа түтгэлзэж, хуулийн байгууллагад энэ асуудлыг шалгуулж, үнэн зөвийг тогтоолгох болно” гээд л мэдэгдчихсэн бол М.Энхболд нэгдүгээр хүн болчих боломж байсан. Даанч Ц.Сандуйд тийм эр зориг байсангүй. Улс төрийн соёл нь ч алга. Улаан цайм “МАН-ын стратегийн асуудал ярьж байсан. Тэр үеийн бичлэг алдагджээ” гэж хэвлэлийнхэнд тайлбар хийсэн хүн нь Ц.Сандуй шүү дээ. Ийм тайлбар яваад байхад эвлүүлэг гэж зүтгээд яах юм бэ. Тэгээд ч Ерөнхийлөгч Х.Баттулга “60 тэрбум”-ын асуудлыг цэгцлэх үүргийг АТГ болон холбогдох албаныханд өгсөн юм чинь энэ хэргийн учиг хурдан тайлагдах биз ээ.

## ДЭЛХИЙ

# МОРОККО ЗАЛУУ ФИНЛАНДАД ХАЛДЛАГА ҮЙЛДЖЭЭ



Б.СУМЪЯА

Финландын баруун өмнөд этгээдийн Турку хотын зах зээлд гартаа хутгатай гэмт этгээд замаар алхаж байсан явган зорчигчид руу халдсаны улмаас хоёр хүн нас барж, найман хүн шархаджээ. Орон нутгийн цагдаагийн газраас мэдээлснээр эл хэргийг террорист халдлага гэж үзэж, хяналт шалгалтаа эхлүүлсэн байна. Хэргийг 18 настай морокко залуу үйлджээ. Сэжигтэн цагдаагийнханд өгсөн мэдүүлэгтээ "эмэгтэйчүүдийг бүрэлгэх" зорилготой байсан гэдгээ хүлээсэн байна. Залууг цагдаа нар үйлдэл дээр нь барьжээ. Энэ удаагийн халдлагаар хоёр хүн нас барж, найман хүн гэмтсэний дотор зургаа нь эмэгтэй байсан гэдгийг "Франц пресс" агентлаг мэдээлсэн юм. Хохирогчдын дунд Итали, Швед, Их Британийн иргэн тус бүр нэг байжээ. Харин үлдсэн хохирогчдын тухайд бүгд финланд хүмүүс байсан байна.

Хэргийн дараа Финланд аюулгүй байдлаа чангатгаж, нисэх онгоцны буудал, галт тэрэгний буудлууд, гудамж талбайд ажиллах цагдаа нарынхаа тоог нэмжээ. Тус улсын Үндэсний аюулгүй байдлын агентлагийн төлөөлөгч "Бид гэмт хэрэгтэн эмэгтэйчүүдийг онилж байсан гэж бодож байгаа. Халдлагаар хохирсон эрэгтэйчүүд бүгд эмэгтэйчүүдээ хамгаалах гэж байгаад шархадсан" гэж ярьжээ.

Цагдаа нар бямба гарагийн үүрээр Турку хотын нийтийн орон сууц, дүрвэгсэд хүлээн авах төвүүдэд тусгай ажиллагаа явуулж, нийтдээ дөрвөн хүнийг энэ удаагийн хэрэгт сэжиглэн баривчилсан байна. Гэхдээ баривчлагдсан хүмүүс хэргийн сэжигтэнтэй холбоотой ч, халдлагатай ямар нэг холбоогүй гэдгээ мэдүүлж байгаа аж.

Хуулийнхан хэргийг үйлдсэн морокко гаралтай 18 настай залууг баривчилсан. Сэжигтэн өнгөрсөн жилийн эхээр Финландад дүрвэгчийн статустайгаар нэвтэрж байжээ. Түүний нэрийг одоогоор албаныхан нийтэд зарлаагүй, мөн хэрэг үйлдэх болсон шалтгаан нь ч тодорхойгүй байгаа юм.

Үндэсний мөрдөн байцаах товчооны төлөөлөгч "Бид эмнэлэгт сэжигтэнтэй ярилцахыг хүссэн ч, тэр юу ч ярихыг хүсээгүй" гэж Франц пресст ярьжээ. Түүний хэлснээр сэжигтэн эдүгээ эмнэлэгт эмчилгээ хийлгэж байгаа юм байна. Тэрбээр баривчлагдах үедээ эсэргүүцэл үзүүлсэн учир гуя хэсэгтээ сумны шарх авч, мэс засал хийлгэсэн аж.

> ...Испанийн Барселона зэрэг хотуудад өнгөрсөн долоо хоногт хэд хэдэн удаагийн террорист халдлага болж, нийт 14 хүн нас барж, 120 гаруй хүн гэмтэж бэртсэн байдаг. Тус халдлагын сэжигтнүүдийн талаас илүү хувь нь морокко гаралтай хүмүүс байсан тул эдгээр халдлагууд хоорондоо холбоотой байж магадгүй хэмээн албаныхан үзэж байна...

Испанид энэ сарын 17 болон 18-ны өдрийн үүрээр мөн террорист халдлага гарсан. Тус халдлагыг лалын хэт даврагч "Исламын улс" бүлэглэл үйлдсэн гэдгээ хүлээсэн юм. Тиймээс Финландад болсон халдлага тус бүлэглэлтэй ямар нэг холбоотой эсэхийг цагдаа нар шалгаж байгаа аж.

Испанийн Барселона зэрэг хотуудад өнгөрсөн долоо хоногт хэд хэдэн удаагийн террорист халдлага болж, нийт 14 хүн нас барж, 120 гаруй хүн гэмтэж бэртсэн байдаг. Тус халдлагын сэжигтнүүдийн талаас илүү хувь нь морокко гаралтай хүмүүс байсан тул эдгээр халдлагууд хоорондоо холбоотой байж магадгүй хэмээн албаныхан үзэж байна. Нийтдээ 5.5 сая хүн амтай Финланд 2015 онд түүхэндээ хамгийн их буюу 32500 дүрвэгсдийг хүлээн авсан юм. Гэвч, өнгөрсөн жилээс Европын бусад орнуудтай адил Финланд ч гэсэн дүрвэгсэд хүлээн авах нөхцлөө чангатгаж, дүрвэгсдийн нийгэмд учруулах хор хөнөөлийг багасгах үүднээс хүлээн авах тоогоо 10 мянгаар бууруулсан байна.

ТЭД БИДНИЙ ТУХАЙ

## Нураах ёстой зургаан байгууламжийн нэгд Чингис хааны морьт хөшөө багтжээ

Вирженіа мужийн Шэрлотсвилл хотод энэ сарын 12-нд гарсан үндсэрхэг үзэлт цагаан арьстнууд болон тэднийг эсэргүүцэгчдийн хооронд болсон мөргөлдөөнтэй холбоотойгоор тус улсад арьс өнгөний асуудал ид яригдаж байна.

Өнгөрсөн долоо хоногийн тухайд америкийн боолчлолын үеийн түүхэн хүмүүсийн хөшөө нь харгислал, дарангуйлалыг илэрхийлж буй учир нураая гэсэн хөдөлгөөн ч өрнөж, зарим их сургуулиудын өмнө байрлах түүхэн хүмүүсийн хөшөөг сүйтгэх болжээ. Эсэргүүцэгчдийн нураах шаардлагатай гэж үзсэн хөшөөнүүдийн тоонд Вашигтон, Жефферсоноос эхлээд Роберт Эдвард Ли, Томас Жонатан Жексон хүртэлх хөшөө ч багтаж байгаа гэнэ. Гэхдээ Ерөнхийлөгч Доналд Трампын ажлын алба тэдгээр түүхэнд нэрээ үлдээсэн хүмүүсийн хөшөө цогцолборыг хамгаалах байр суурьтай байгаагаа илэрхийлж байгаа юм. Тэдний нэг нь Стив Бэннон. Стив Бэннон Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх төдийгүй Цагаан ордоны ахлах стратегичаар ажиллаж байсан. Гэхдээ өнгөрөгч долоо хоногт албан тушаалаа өгч, цагаан ордныг орхисон юм. Хэдий албан тушаалаа өгсөн ч тэрбээр Доналд Трампыг хамгаалсаар байх болно гэдгээ мэдэгдсэн байдаг. Стив Бэннон Трампын сонгуулийн кампанитыг удирдаж байсан нэгэн. Хэт барууны үзэлтэй бөгөөд цагаан арьстныг дөвийлгөх үзэлтэй гэгддэг. Үүнийгээ ч өмнө нь нууж байгаагүй юм билээ.

Тэгвэл түүний удирдаж буй "Breitbart News" вэбсайт хэрвээ Америкчууд түүхэн хүмүүсийг боолчлогчид гэж үзэн хөшөөг нь нураах хүсэлтэй байгаа бол эхлээд дэлхий дээр байгаа тэднээс ч аймшигтай алуурчид, боолчлогчдын хөшөөг нураах хэрэгтэй гэж мэдээлсэн байна. Тус сайт үүндээ зургаан хөшөө байгууламжийг жагсаасан байх бөгөөд тэдний дунд манай улсын нутаг дэвсгэрт оршдог Чингис хааны морьт хөшөө багтжээ.



Тус сайтын "Чингисийн морьт хөшөө"-ний доорх тайлбар хэсэгт "Энэ хөшөөг дундад зууны үед дэлхийн талыг эзэгнэж явсан Их Монгол улсыг үндэслэгч Чингис хаанаас сэдэвлэн босгосон. Нийслэл хотоос 33 миллийн зайд байрлах 130 фүүт өндөр энэ хөшөө өнөөгийн монголчуудын хувьд биширмээр зүйл биш. Чингисийн армийн хөнөөсөн, хүчирхийлсэн бүх гэм зэмгүй хүмүүсийн хувьд эл хөшөө хүндээр тусах бус уу. Түүхчдийн тооцоолсноор 13-14 дүгээр зууны үеийн Түрэг-Монголын түрэмгийллийн үеэр тухайн үеийн дэлхийн хүн амын таван хувь нь алагдсан байна. Түрэмгийлэлд өртсөн улс орнууд дахин хэзээ ч сэргээгүй гэдгийг зарим түүхчид ч батладаг билээ. Үүнийг түүхэн дэх шударга бус байдал гэж нэрлэх бөгөөд хэдий хэрийн цаг хугацаа улиран өнгөрснөөс үл хамааран засч залруулах ёстой. Гэтэл зүүнийхэн яагаад монголчуудаас нөхөн төлбөр нэхэхгүй байна вэ" хэмээн бичсэн байна. Бусад нураах ёстой хөшөө дурсгалуудад АНУ дахь Жефферсоны дурсгал, Турк дэх Оттоманы үеийн Хөх сүм, Төв Америк дахь Майя нарын пирамид, Хятадын цагаан хэрэм, Египетийн Гизагийн пирамид багтжээ. Тэдгээрийг олон сая хүний амь нас, боолын хөдөлмөр шингэсэн байгууламжууд гэж үзсэн байна. Тухайлбал, дэлхийн долоон гайхамшгийн нэг гэгддэг цагаан хэрэмний тухайд тус сайтад "Хятадын цагаан хэрэм бол дэлхийн хамгийн гайхалтай инженерийн бүтээлийн нэг. Гэхдээ энэ харгислал, дарангуйллын хэрэм юм. Хэрмийг боолуудаар бариулаагүй. Гэмт хэрэгтэн болон цэргүүдээр бариулсан гэдэг. Гэхдээ тайвширч болохгүй. Цагаан хэрэм бол дэлхийн хамгийн урт оршуулга. Энэ байгууламжийг барихад нэг сая ажилчин нас барсан" хэмээн бичжээ.


# СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Сонгон шалгаруулалтын нэр: МҮОНТ-ийн кино контент бүтээхэд шаардлагатай киноны видео камер болон дагалдах хэрэгсэл, дуу бичлэгийн тоног төхөөрөмжийг худалдан авах

Сонгон шалгаруулалтын дугаар: ¹2017-17

4К технологийн стандартын шаардлага хангасан видео камер, дуран бусад дагалдах хэрэгсэл болон дуу бичлэгийн иж бүрэн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага:

*/хүснэгтээс харах/*

Эрх бүхий этгээд нь сонгон шалгаруулалтын материалд дараах зүйлсийг заавал тусгасан байна. Үүнд:

- Нээлттэй сонгон шалгаруулалтанд оролцох албан хүсэлт
- Байгууллагын гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан хувь/
- Байгууллага, аж ахуйн нэгжийн танилцуулга, энэ чиглэлээр ажилласан туршлага, фото зураг болон видео бичлэгийн аль нэгийг ирүүлэх
- Үнийн санал /НӨАТ, гааль, тээвэр, суурилуулалт болон бусад бүх зардал шингэсэн/
- Төлбөрийн хөнгөлөлт

МҮОНТ-ээс зөвхөн тухайн сонгон шалгаруулалтад шалгарсан байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд эргэн хариу мэдэгдэнэ.

*Сонгон шалгаруулалттай холбоотой тодруулга авах утас: 70117004, 88119617*

*Холбогдох материалыг битүүмжлэн 2017 оны 08-р сарын 25–ны өдрийн 10.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлнэ үү?*

*Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалын зам-3, МҮОНРТ-ийн байр, 2 давхар, СОБХ-ийн нягтлан бодогч нарын өрөө*

### ДУУ БИЧЛЭГИЙН ТЕХНИК ХЭРЭГСЭЛ

| No. | "ТЕХНИК ХЭРЭГСЭЛ " | ЗАГВАР | МАРК | ТОО | ТЕХНИК ҮЗҮҮЛЭЛТ, ТАЙЛБАР |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дуу бичлэгийн аппарат | Zoom | F8 | 1 | Найман сувагтай, зөөврийн, тоон аппарат, 8 ш XLR оролттой, SD санах ойтой, TC хянагчтай, (AD-19 12v тэжээлтэй, 2xTA3 to XLR кабель) |
| 2 | Зориулалтын цүнх | Zoom | PCF-8 | 1 | Бичлэгийн аппаратны цүнх, усны хамгаалалттай, тал бүрээс наалтаар нээгдэх зориулалтаар хийгдсэн, ил харагдах тунгалаг хаалттай, зөөвөрлөх зориулалтын үүргэвчтэй |
| 3 | Мемори карт | Sandisk | UHS-I SDXC | 6 | Олон цагийн бичлэг хадгалах боломжтой 64 GB санах ойтой, UHS-I SDXC |
| 4 | Тэжээлийн блок | Tilta | BMCC | 1 | "V-Lock батерейн ток хувиарлагч тэжээлийн систем, гаралтын кабель утаснуудын хамт, гаралт нь : 5v, 7.5v, 12v, 14v г.м" |
| 5 | Микрофоны багц | SONY | UWP-D | 3 | "Тоон утасгүй микрофоны багц, орчны чиглэлийн энгэрийн микрофонтой, хөнгөн цагаан гадартай /AA батерэй цэнэглэдэг зайгаар ажилладаг/" |
| 6 | Хамгаалалтын хуванцар хайрцаг | | | 1 | 50*40*30cm хэмжээтэй доргилт, цохилт, тоос шорооны хамгаалалттай хайрцаг |
| 7 | Чихэвч | SONY | MDR7506 | 2 | Дуу чимээ хязгаарлагчтай мэргэжлийн чихэвч |
| 8 | Батерей цэнэглэгч | Powerex | MH-C801D | 2 | AA хэмжээтэй батерейг зэрэг цэнэглэх цэнэглэгч (1.2V, 2700mAh) 8 ш оролттой |
| 9 | AA хэмжээтэй цэнэглэдэг батерей | Powerex | NiMH AA | 8 | AA хэмжээтэй цэнэглэдэг батерей, 8 ширхэгээр савлагдсан |

### ДҮРС БИЧЛЭГИЙН ТЕХНИК ХЭРЭГСЭЛ

| No. | ТЕХНИК ХЭРЭГСЭЛ | ЗАГВАР | МАРК | ТОО | ТЕХНИК ҮЗҮҮЛЭЛТ, ТАЙЛБАР |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дүрс бичлэгийн аппарат | A7Sii | A7Sii | 2 | 4K 25fps бичлэг хийх чадалтай дүрсний камер |
| 2 | Дуран (Cine) | Samyang | 14mm | 1 | 14mm T3.1 VDSLRII Cine дуран |
| 3 | Дуран (Cine) | Samyang | 35mm | 2 | 35mm T1.5 VDSLRII Cine дуран |
| 4 | Дуран (Cine) | Samyang | 85mm | 2 | 85mm T1.5 VDSLRII Cine дуран |
| 5 | LED гэрэл | | 1080W | 2 | 3200-5500K Хосолсон өнгийн, бууруулагчтай гэрэл |
| 6 | Гэрэл ойлгогч (Подсвет) | | 6 in 1 | 2 | Зургаан төрлийн хэрэглээтэй гэрэл ойлгогч |
| 7 | Micro HDMI to HDMI Кабель | | | 3 | Micro HDMI-ийг стандарт HDMI-луу шилжүүлэх холбогч кабель |
| 8 | Хамгаалалтын хуванцар хайрцаг | | | 2 | 40*30*25cm хэмжээтэй доргилт, цохилт, тоос шорооноос хамгаалах зориулалттай |

ЦАГ ҮЕ

# Н.Цэдэндамба:

## БИ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦЫН 50 ЖИЛИЙН ТҮҮХИЙГ БИЧИЛЦСЭН ХҮН



О.УЯНГА

*Дулааны хоёрдугаар цахилгаан станцын анхны инженер, ахмадын зөвлөлийн дарга асан Н.Цэдэндамбатай ярилцлаа. Тэрбээр хоёрдугаар цахилгаан станцыг анх ашиглалтад орохоос нь эхлээд 50 жилийнхээ ойг хийх хүртэл ажилласан ахмад инженер юм.*

**-Та Дулааны хоёрдугаар цахилгаан станцын тулгын чулууг тавилцаж байсан анхдагчдын нэг. Тэр чигээрээ энэ станцын амьд түүх. Тиймээс энэ станцтай холбогдох болсон түүхээ эргээд нэг дурсаач?**

-Би идэр залуудаа боловсролын байгууллагад ажиллаж байлаа. 1947 онд долдугаар анги төгсөөд, Боловсролын сургуулийн дунд ангийн багш бэлтгэдэг хоёр жилийн сургалтад сурсан. Ингээд тоо, физикийн багш гэсэн үнэмлэх аваад, Өвөрхангай аймгийн төвийн сургуульд очиж ажилласан. Тэгэхэд Арвайхээрийн сургууль 10 жилийн сургалттай болоогүй байсан. Найман жил байхад нь очиж байсан гэсэн үг. Очоод хоёр жил багшлаад байж байтал аймгийн Гэгээрлийн хэлтэст байцаагчаар томилчихдог юм байна. Тэнд хоёр жил ажилсаны дараа багшилмаар байна гэсэн хүсэлт гаргасан. Гэтэл төвийн 10 жилийн сургуульдаа буцаад оч гээд 1953 онд эргээд багшилж эхэлсэн. Ингээд 1953-1955 он хүртэл төвийн 10 жилийнхээ сургуульдаа багшилж байтал Уянга суманд долоон жилийн сургууль байгуулагддаг юм байна. 1955 онд Уянга сумын сургуульд хичээлийн эрхлэгчээр очиж ажилла гэсэн. Ингээд л Уянга руу явж, хоёр жилийн хугацаанд ажиллаж, анхны төгсөгчдийг нь төгсгөж гаргаж байлаа. Уянга сумын сургуульд ажиллаж байх хугацаандаа дахин суралцмаар байна гэсэн өргөдөл хэд хэдэн удаа өгсөн юм. Гэтэл 1957 онд надтай нийлээд дөрвөн хүнээс сургуульд явуулахаар шалгалт авсан. Ингээд л Р.Цоодол гэдэг хүн бид хоёрыг сургуульд явахыг зөвшөөрсөн. Тэгээд тэр жилдээ МУИС-ийн физикийн ангид элсч, суралцсан даа. Олон эрдэмтэн багш нарын хүчинд сайн ч суралцсан. Сайхан ч байсан. 1961 онд сургуулиа төгслөө. Сургууль төгссөний дараа Намын төв хорооны боловсон хүчин дуудаад, Өвөрхангай аймагтаа Боловсролын хэлтсийн даргаар явна шүү гэсэн. Би ч за гэж хэлчихээд л гарсан. Дараахан нь Намын төв хорооны боловсон хүчнээс явж байна гээд нэг хүн ирлээ. Үйлдвэрт очиж ажиллах саналтай хүн байвал бүртгүүлээрэй гэж байна. Тэр үед залуу хүн хөөрүү ч байсан юм болов уу. Үйлдвэр гэхээр л сайхан санагдаад, шинэ зүйл үзэж, мэдэрье гээд саналаа өгсөн. Гэтэл намайг Аж үйлдвэрийн яаманд хуваариллаа. Яаманд очсон чинь П.Дамдин сайд хүлээж авч байна. Ингэж л хоёрдугаар цахилгаан станцад очиж ажиллах зам нээгдсэн түүхтэй.

**-Таныг анх хоёрдугаар цахилгаан станцад очиход ямар байв. Ашиглалтад орсон байсан уу?**

-Ашиглалтад ороогүй байсан юм. Анх очиход баахан хятадууд бужигнаад л. Барилгын дээвэр, оройн хэсэг нь гүйцээгүй. Хятадууд угсралт, монтаж хийгээд. Хятад хүүхнүүд нарийн монтаж хийдэг бололтой, ажиллаж байлаа. Бид тэрийг нь нэлээд харж, ажиглана. Хийж байгаа тоноглолуудын байрлуулж байгаа байршил, шугам хоолойг угсарч байгааг ажигладаг байлаа. Цахилгаан станцын барилгын ажил 1961 оны арваннэгдүгээр сарын орчимд дууссан. Ингээд хятадууд өөрсдөө бие дааж, турших маягаар ажиллуулсан юм. Анх ажиллуулахад бидэнд ямар ч зүйлд хүрэх эрх байхгүй байсан. Хятадуудын хийж байгаа ажлыг хараад, дагалдаж яваад, өнөөдүүлээс чинь асуугаад л. Нэг нэг хэлмэрчтэй, түүгээрээ дамжуулаад л ярина, тайлбарлуулна. Би чинь анх ээлжийн инженерээр томилогдож очсон юм шүү дээ. Тэгээд зуух, турбинаас авахуулаад бүхий л тоног төхөөрөмж яаж ажилладагийг нь хятадуудаасаа асууж байгаад л сурсан даа. Эхлээд нэг хэсэг туршилтын журмаар ажиллуулж байгаад сүүлээд албан ёсоор ашиглалтад орсон. Биднийг шууд л нэг нэг ажилд томилчихож байгаа юм. Хоёрдугаар цахилгаан станцыг өөрсдөө мэдэж удирдаж, ажиллуулж эхэлсэн гэсэн үг.

**-Тэр үед нэгдүгээр цахилгаан станц гэж байсан бил үү?**

-Төв цахилгаан станц гэж нэрлэдэг байсан юм. Аж үйлдвэрийн комбинат дотор байлаа. Ерөөсөө Улаанбаатар хотод ганц цахилгаан ажиллаж байсан нь тэр. Манайх хоёр дахь нь болж, ашиглалтад орсон. Манай станц чинь 75-ын гурван зуухтай, 6000 Квт-ын хоёр жижиг турбинтай, 12 мвт-ын хүчин чадалтайгаар ашиглалтад орж, Толгойтын районыг эрчим хүчээр хангадаг байлаа. Хоёр цахилгаан станц хоорондоо холбогдоогүй. Манайх нэг хэсгийг, төв станц бусдыг нь хариуцаж ажиллаж байсан даа. Эхлээд байгуулагдсан хүчин чадлаараа 10 орчим жил ажилласан. Тэгээд 1970 онд Оросууд нэг өргөтгөл хийсэн. Тухайн үеийн ЗХУ-ын тусламжтайгаар станцаа өргөтгөж, 24 мвт-ын чадалтай болж байлаа. Түүнээс хойш өргөтгөл, шинэчлэл огт хийгдээгүй л өдийг хүрч байна даа.

**-Тухайн үед Улаанбаатар хотын хүн ам цөөн, суурьшил багатай байсан болохоор цахилгаан станцын хүчин чадлаа ч багаар тооцож барьсан байх нь уу?**

-Мэдээж тухайн үеийнхээ хэрэгцээ шаардлагад л нийцүүлж барьсан байх. Толгойтын тэр хавиар чинь олон айл, үйлдвэр, аж ахуй нэгж байгаагүй юм. Мах комбинат, тэгээд бага шиг гэр хороолол л байсан. Манай станц мах комбинатыг технологийн уур, цахилгаанаар хангана. Таван шарыг бас дулаан, цахилгаанаар хангана. Тэгээд ч таван шар чинь бүр сүүлд төвийн дулаанд холбогдсон юм.

**-Та анх 1961 онд хоёрдугаар цахилгаан станцын нэг эд эс болж байж. Энэ байгууллагад хэчнээн жил ажиллаж, ямар ямар албан тушаал хашиж байв даа?**

-Хамгийн анх жижүүрийн инженерээр томилогдож очиж байсан юм. Ээлжинд гардаг ажил л даа. Хэдэн жид ажиллаж байтал манай дарга Гүрбазар гэдэг хүн “Чи Үйлдвэрчний хороон дарга болооч. Одоо байгаа Үйлдвэрчний хороон даргатай хэл амаа сайн ололцохгүй байна. Дараа чамайг дуртай ажилд чинь томилно” гэлээ. Ингээд нэг жил Үйлдвэрчний хороон дарга хийлээ. Станцын хүн биш ч юм шиг. Хотын Үйлдвэрчний хороон дээр ирж цалингаа авдаг, гишүүдийнхээ татварыг аваачиж тушаадаг тийм хачин ажил. Тэгээд сүүлдээ даргадаа “Би эрчим хүчнийхээ инженерийн ажлыг л хийе. Энэ ч бүтэхгүй юм байна” гээд хэллээ. Гэтэл дарга “Чиний оронд ямар хүн өгдөг” бол гэж байна. Харин Үйлдвэрчний байгууллага Дархан хотод ажиллаж байсан Муураа гэдэг хүнийг миний оронд томилъё гэж байна. Тэрийг нь даргадаа танилцуулсан чинь их дуртай хүлээж авсан. “Муураа ирэх гэж байгаа юм бол чи наад ажлаа болиод, инженерээ хий дээ” гэдэг юм байна. Ингээд л Муураа гуайд ажлаа хүлээлгэж өгчихөөд, тооцооны инженер болсон.

**-Тооцооны инженер гэхээр яг ямар ажил хийх үү?**

-Зуух, турбинуудаас гарч байгаа бүхий л уур, цахилгааныг тооцно. Цахилгаан, дулааны тооцоогоо сүлжээнүүдтэй сарын эцэст хийнэ. Танайд манайх энэ сард төчнөө уур, өчнөөн сүлжээний ус өгсөн гээд л дулааны сүлжээтэй тооцоогоо хийнэ. Цахилгаан сүлжээтэй бас тооцоогоо хийнэ. Хоёр шугам сүлжээнээс өгсөн дулаан, цахилгааныхаа үнийг авна. Тэр мөнгөөрөө санхүүжиж л явна шүү дээ. Ер нь бол Дулааны хоёрдугаар цахилгаан станц түүхтэй, сайхан байгууллага. Манай станцыг анх ашиглалтад ороход Аж үйлдвэрийн орлогч сайд байсан Тогоо гуай ерөнхий инженерээр ажиллаж байлаа. Манайд нэг жил ажиллачихаад Аж үйлдвэрийн яамны орлогч сайд болоод явсан. Манайх чинь Тогоо гуайгаас эхлээд дөрвөн гавьяат дарга төрүүлсэн байгууллага. Бусад станцууд дотроо хамгийн их үүх түүхтэй нь манайх.

**-Та хоёрдугаар цахилгаан станцаасаа тэтгэвэрт гарсан уу. Хэчнээн жил ажиллав?**

-Хоёрдугаар цахилгаан станцаасаа л тэтгэвэртээ гарсан. Би уг нь 63 хүрээд тэтгэврээ тогтоолгох хүсэлтээ өгсөн юм. Гэтэл дарга нар та ажиллаж л бай гэсэн. Сүүлд станцын зөвлөх инженер, Ахмадын зөвлөлийн дарга гэсэн хоёр ажлыг хийж байгаад 2011 онд тэтгэвэртээ гарсан. Станцынхаа 50 жилийг ойг тэмдэглүүлчихээд л гавьяаныхаа амралтад суусан гэсэн үг. Станцын 50 жилийн ой хийхэд анхны ажилтнууд нь цөөхөн. Би чинь нэг лавлах шиг л байлаа. Эхлээд цахилгаан станц ажилд орж байхад ямар хүн, аль албан тушаалыг хашиж байв гэдгийг надаас асууна. 50 жилийн ойн ном хийхэд нь гол материалыг нь бэлдэлцэж өгсөн. Ойгоо өнгөрөөгөөд л 2011 оны сүүлчээр тэтгэвэртээ гарсан. Хоёрдугаар цахилгаан станцад 50 жил л ажилласан хүн дээ, би.

**-Цахилгаан станцын ажил хүнд байх. Тэр дундаа жижүүрийн инженерийн ажил яггүй биз?**

-Жижүүрийн инженер хийхэд бүхий л дамжлагийг хянана. Туузан дамжлагаар нүүрс явж байна. Түүнийг чинь нунтаглана. Тоос ихтэй орчинд ажиллана. Тийм орчинд ажиллаж байснаас болоод уушигны тоосжилттой болчихсон. Одоо нэлээд ханиалгана аа. Ер нь тийм амар ажил биш шүү дээ. Гэхдээ яах вэ, дассан сурсан ажил болохоор насаараа хийгээд, зүтгээд л ирсэн. Одоо манай гурван хүү гурвуулаа эрчим хүчний чиглэлээр ажилладаг. Хоёр нь миний ажиллаж байсан станцад ажилладаг. Нэг нь бүр жижүүрийн инженер хийж байгаа саяхнаас сургалтын инженер болсон. Дунд хүү маань Үйлдвэр техникийн хэлтсийн даргын алба хаштдаг. Том хүү маань MCS группийн Эрчим хүчний компанид ажилладаг. Ингээд л үе удмаараа эрчим хүчний чиглэлээр ажиллаад явж байна даа.

**-Хоёрдугаар цахилгаан станц бараг хэрэггүй юм шиг яриа гарах нь бий. Насаараа энэ байгууллагад ажилласан хүний хувьд та энэ тал дээр нэгийг хэлэх байх?**

-Тийм хүмүүс байсан юм. Удахгүй нэг том цахилгаан станц барина. Тэгээд танайх бараг хэрэггүй дээ гээд Эрчим хүчний сургалтын төвийг манай хашаанд барьсан. Тэгээд Багануурт том станц ашиглалтад орохоор танайх сургалтын төвийн үзүүлэн болно гэсэн яриа ч гарч байлаа. Тэр шийдвэр л манайхыг гацаасаар байгаад л зах зээлтэй золгуулсан даа. Өргөтгөл, шинэчлэл ч хийгдээгүй. Өөрийнхөө хөрөнгөөр л дотроо жаахан засвар хийхээс өөр өөрчлөгдсөн юм байхгүй. Гэхдээ хоёрдугаар цахилгаан станц одоо ч өөрийнхөө хэмжээнд ажиллаж байна. Тэнд ажиллаж байгаа инженер, техникийн ажилчид гээд 300 гаруй хүн байгаа. Хэрвээ Дулааны хоёрдугаар цахилгаан станцыг хаалаа гэвэл 24 мвт, тэгээд бас үйлдвэрлэж байгаа дулаан нь дутагдаад л явчихна. Ажилчид нь хаана очиж, юу хийх юм. Тийм болохоор би одоо энэ станцыг өөд нь татах байх гэж бодож явдаг.

**-Станцуудын насжилтын асуудлыг хөндөх цаг болсон гэж учир мэдэх хүмүүс яриад эхэллээ. Та энэ тал дээр юу хэлэх вэ?**

-Гадаадад 50 жил ажилласан цахилгаан станц байдаггүй гэж хүмүүс ярих юм билээ. Тэгээд бодохоор Монголын цахилгаан станцууд насжилтаараа дээгүүрт бичигдэж байгаа юм болов уу гэж боддог.




# ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +15
Шөнө +10

Нөгөөдөр
Өдөр +16
Шөнө +5

## Өдрийн зурхай

**ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААН ЛУУ ӨДӨР**

**Үс засуулбал:**
*Эрлэг лугаа учирна*

**Наран ургах, шингэх:**
*05.59-19.52*



Аргын тооллын 8 сарын 21, Сумъяа гараг. Билгийн тооллын битүүн, Үнэг одтой, цагаан луу өдөр. Өдрийн наран 5 цаг 59 минутад мандан, 19 цаг 52 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд ээрэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, лус тахих, хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

# Виктор Слипенчук: "Чингис хаан" найраглалыг би нэг одорт бичиж байсан




Н.БОЛД

*Улаанбаатар хотноо Дэлхийн яруу найргийн өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлж байгаа билээ. Энэ хүрээнд Дэлхийн яруу найрагчдын 37 дугаар их хурал болсон. Мөн "Данзанравжаа" Олон улсын яруу найргийн наадам ч болсон. Дэлхийн яруу найргийн өдрүүдийн хүрээнд манай улсад 40 орчим орны 200 гаруй зохиолч, яруу найрагч, урлаг соёлын зүтгэлтнүүд хүрэлцэн ирээд байгаа. Тэдний зарим нь өөрийнхөө зохиол бүтээлийг монгол хэлнээ хөрвүүлэн, нээлтийг нь хийж байгаа юм. Тэгвэл өнгөрсөн баасан гарагт Оросын зохиолч Виктор Трифонович Слипенчукийн "Оддын аврагч" роман, "Чингис хаан" найраглалын нээлт Тусгаар тогтнолын ордонд болсон юм. Энэ үеэр түүнтэй цөөн хором ярилцлаа.*

**-"Чингис хаан" гэдэг найраглалыг бичих сэдэл хаанаас төрсөн бэ?**

-Би тэр үед их залуу байжээ. Цэрэгт байсан явах гэж байсан үе. Миний найз Валерий гэж залуу байсан. Тэр найз маань амьдралдаа хоёрхон хүнийг л шүтдэг байсан. Нэг нь Сталин, нөгөөх нь Чингис хаан. Найзууд чинь бие биедээ их нөлөөлдөг шүү дээ. Тиймдээ ч би Чингис хааны тухай бодож, санаж байж энэ найраглалыг бичсэн. Анх найраглал бичих сэдлээ тэгж л олж авсан даа. Алтай мужийн Хөдөө аж ахуйн сургуульд суралцаж байхад Крилов гэдэг найз маань миний бага сага бичсэн байсан найраглалын зургийг дүрслээд зурчихсан байсан юм. Олон жилийн дараа тэр зургуудын ихэнх нь хаягдчихсан юм. Би харин заримыг нь олоод судар хэлбэрээр хэвлэгдсэн "Чингис хаан" номондоо оруулж өгсөн. Тэр найз маань надад "Би Чингис хаантай ойролцоо төрхтэй. Миний хөл хүртэл майга байгаа биз дээ" гэж хэлдэг байсан юм.

**-"Чингис хаан" найраглалыг хэдэн онд бичсэн бэ. Энэ найраглалыг бичсэнээс болоод хэлмэгдэж байсан гэх аман яриа байдаг. Яг тийм зүйл болсон юм уу?**

-Би бяцхан түүх яримаар байна. Миний амьдралд маш олон хүн тусалж, дэмжиж байсан гэдгийг хэлье. Тэр дундаа Оросын нэртэй газар зүйч, эрдэмтэн Андрей Петрович Капицов их тус болж байсан. Ер нь олон нэртэй эрдэмтэд надад тусалж байсан болохоор элдэв асуудалгүй өнгөрсөн байх. Тэгээд ч би 1964 онд цэрэгт байхдаа "Чингис хаан" найраглалыг бичсэн. Харин энэ найраглал маань бүр сүүлд хэвлэгдсэн болохоор элдэв асуудал байхгүй л дээ. Яахав, манайд энэ найраглалын гар бичмэл, найзын маань зурсан зураг энэ тэр байдаг байсан. Түүнийг олж үзсэн хүмүүс цөөнгүй байсан ч гайгүй өнгөрсөн шүү.

**-Хэдийгээр найз чинь Чингис хааныг шүтдэг байсан ч гэсэн энэ найраглалыг бичихийн тулд тодорхой хэмжээнд судалгаа хийсэн байх?**

-Бүх зүйл маш хялбар. 17 залуу 70 настай хүн шиг ч сэтгэж болно. Зохиолч, яруу найрагчид зохиолоо ургуулан бодож, түүнийгээ хөгжүүлж бичиж бас болно. Хүний сэтгэл байхад мэдлэг боловсрол, судалгаа шинжилгээнээс ч илүү байж болдог гэдгийг би тэр үедээ мэдэрч байсан. Би "Чингис хаан" найраглалыг ганцхан өдрийн дотор л бичсэн. Үүнээс өмнө Чингис хаантай холбоотой үүх түүх бараг уншаагүй. Судалгаа, шинжилгээ хийгээгүй. Янгын нэг зохиолыг уншиж байсан. Тэр зохиол миний найраглалаас тэс өөр гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Тэгээд ч тухайн үед цэрэг байсан. Чингис хааны тухай ном, зохиол, түүх олж унших боломж ч байгаагүй. Тийм түүх, зохиол, ном ч байхгүй шахуу байсан үе шүү дээ. Энэ бол зөвхөн миний л оюун бодлоос гарсан бүтээл. Чингис хаан тухайн үед ингэж бодож байсан болов уу гэж бодож л бичсэн. "Чи чинь юу бичээд байгаа юм бэ. Наадах чинь хэзээ ч хэвлэгдэхгүй шүү дээ" гэж надад маш олон хүн хэлж байсан. Гэвч би өөртөө зориулж бичиж байгаа юм гэж хэлдэг байлаа. Би хамгийн анх 14 настайдаа шүлэг, зохиол бичиж, оролдож эхэлсэн. Бүр бага байхаасаа л яруу найрагч болно гэдгээ би мэддэг байсан юм.

**-Ер нь бол Монголын түүхийг хэр судалсан бэ. Тэр дундаа Чингис хааны тухай их уншиж, судалсан байх?**

-Би нэг л юм хэлье. Одоо бол би Чингис хааны тухай иим найраглал хэзээ ч бичиж чадахгүй. Бичихгүй. Энэ насан дээр ирчихээд эргээд харахад , тухайн үед би залуу, цэргийн алба хааж байсан. Өөрийнхөө бичсэн найраглалаас ганц хоёр бадаг уншихаар цэргүүдэд маш таалагддаг байсан. Тэр үедээ би үнэхээр жаргалтай байсан. Харин одоо бол би дахиж ийм зүйл бичихгүй, оролдох ч үгүй. Яагаад гэвэл маш хэцүү. Би яг үнэнээ л хэлж байна.

**-"Чингис хаан" найраглалыг уншиж байхад тэр хүний бодролыг маш гайхалтайгаар бичиж чадсан юм шиг санагдсан?**

-Сербийн нэг эрдэмтэн "Энэ найраглалыг уншаад европчууд анх удаагаа Чингис хааныг арай өөр өнцгөөр харах болно" гэж хэлж байсан. Чингис хааныг дарангуйлагч мэтээр л гадных ихэнх хүмүүс хардаг шүү дээ. Гэтэл тэр хүн чинь юм боддог, гуниглаадаг, баярладаг, бахархдаг байсан шүү гэдэг талаас нь харуулж чадсан.




ХОЛЛИВУДЫН СОНИН ХАЧИН

## ПАРИС ХИЛТОН Д.Трампыг өмөөрч байсныхаа төлөө УУЧЛАЛТ хүслээ

Б.ДАВАА

Алдарт Хилтон зочид буудлын өв залгамжлагч, авьяаслаг DJ Парис Хилтон АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампыг өмөөрч байсныхаа төлөө уучлалт хүсчээ. Тэрбээр өнгөрсөн жилийн арваннэгдүгээр сард "Marie Claire" сэтгүүлд ярилцлага өгөхдөө өнөөгийн Ерөнхийлөгч Доналд Трампыг хайрлаж, хүндэлж, биширч явдаг хэмээн магтаж байсан аж. Үүний зэрэгцээ Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө цацагдсан Трампын эмэгтэйчүүдийг доромжилсон зүй бус үгсийн талаар "Би эрчүүдтэй ажилладаг. Эрчүүд тиймэрхүү галзуу зүйл ярихыг нэг бус удаа сонсож байсан" хэмээн өмөөрч байсан удаатай. Тэгвэл Парис саяхан "Us weekly" сэтгүүлд ярилцлага өгөхдөө өнгөрсөн жил сэтгүүлд өгсөн ярилцлагынхаа төлөө эмэгтэйчүүдээс уучлалт гуйжээ. Улмаар цаашид эмэгтэйчүүдийг дэмжиж, туслана гэдгээ мэдэгдсэн байна.

FOOTBALL NEWS

## "Манчестер Юнайтед", "Ливерпүүл" ХОЖИЖ, "Арсенал" ХОЖИГДЛОО

Английн премьер лигийн хоёрдугаар тойргийн эхний тоглолтууд өнгөрсөн бямба гарагийн орой боллоо. Эхний тойрогт өрсөлдөгчөө 4:0-ээр буулгаж авч, улирлыг гайхалтай эхлүүлсэн "Манчестер Юнайтед" клуб энэ удаад "Соунси"-гийн талбайд зочиллоо. "Улаан чөтгөрүүд" энэ тойрогт ч гайхалтай байж, өрсөлдөгчөө 0:4-өөр бутниргэлээ. Ингэснээр хоёр тоглолт дараалан дөрвөн гоол оруулж, хаалгандаа ганцыг ч алдсангүй. "Соунси"-гийн эсрэг 45 дахь минутад Эрик Байи гоолдож, тооны харьцааг нээсэн. Улмаар 80 дахь минутад Лукаку улирлын гурав дахь гоолоо оруулсан бол хоёр минутын дараа Погба нэгийг нэмжээ. Тэгвэл Марсьяль 84 дэх минутад гүйцээжээ. Хоёрдугаар тойрогт "Ливерпүүл" клуб талбайдаа "Кристал Палас"-ыг хүлээж авлаа. Энэ тоглолтод "Улаанууд" өрсөлдөгчөө 1:0-ээр буулгаж авсан. Ингэснээр эхний хоёр тойрогт нэг тэнцэж, нэг хожоод байна. Тоглолтын хувь заяаг шийдсэн цорын ганц гоолыг 73 дахь минутад Садьо Мане оруулжээ. Тэгвэл эхний тойрогт гайхалтай хожлыг байгуулсан "Арсенал" клуб энэ удаад "Сток Сити"-гийн талбайд зочилж, 0:1-ээр хожигдлоо. Тоглолтын хувь заяаг шийдсэн цорын ганц гоолыг 47 дахь минутад Хесе оруулжээ.